

# ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ДҮРЭМ

## Нэгдүгээр бүлэг.

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Цэрэгжлийн спорт гэдэг нь батлан хамгаалах чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулдаг төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний байлдааны болон мэргэжлийн бэлтгэлийн ур чадварыг дээшлүүлж, бие бялдар, сэтгэл зүйн өндөр ачааллыг даван туулах чадварыг хангахад чиглэсэн спортын төрлүүдийг багтаасан биеийн тамирын зорилтот үйл ажиллагааг хэлнэ.

1.2. Цэрэгжлийн спортын төрлүүдээр тэмцээн, уралдаан явуулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийг мөрдөнө.

1.3. Тэмцээнийг зохион байгуулах болон тэмцээнд оролцох журмыг тэмцээнийг санаачлан, зохион байгуулах байгууллагаас гаргаж, батлагдсан тушаал, шийдвэр, нэгдсэн заавар, удирдамжаар тодорхойлно.

1.4. Цэрэгжлийн спортын төрлүүдээр явагдах тэмцээнтэй холбоотой шагналын болон бусад холбогдох зардлыг тухайн тэмцээнийг санаачлан, удирдан зохион байгуулах байгууллага хариуцана.

## Хоёрдугаар бүлэг.

### ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Цэрэгжлийн спортод доорх төрлүүд хамаарна.

2.1.1. Цэрэгжлийн гимнастик /сонс эргэх, модон моринд малгай тавьж харайх, чөлөөт хөдөлгөөн/;

2.1.2. Цэрэгжлийн буудлага /гар бууны тогтоол, автоматын буудлага, гар бууны хурдан буудлага/;

2.1.3. Цэргийн гурван төрөлт /буудлага, гранат шидэлт, 3000 метр гүйлт/;

2.1.4. Туухай өргөлт /жингийн ангилал/;

2.1.5. Гардан тулаан /жингийн ангилал/;

2.1.6. Өвлийн хоёр төрөлт /биатлон, патруль/;

2.1.7. Цэрэг, спортын цогцолбор зуны олон төрөлт /насны ангилал/;

2.1.8. Цэрэг, спортын цогцолбор өвлийн олон төрөлт /насны ангилал/;

2.1.9. Саадын зурвас /хувиар болон багаар/;

2.1.10. Мэргэн буудагчийн хоёр төрөлт /биатлон, патруль/;

2.1.11. Марш тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн /байнгын бүрэлдэхүүний салаа, хугацаат цэргийн алба хаагчдын салаа, эмэгтэй ЦАХ-дын тасаг/;

2.1.12. Цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн /батальоны захирагч, ротын захирагч, салааны захирагч, эмэгтэй офицер, эрэгтэй ахлагч, эмэгтэй ахлагч/;

2.2. Цэрэгжлийн спортын төрлүүдээр зохион байгуулагдсан тэмцээнүүдэд гаргасан амжилтын үзүүлэлтийг зөвхөн Монголын Цэрэгжлийн спортын холбоо /МЦСХ/-ны төлөвлөгөөнд тусгагдсан албан ёсны /Зэвсэгт хүчний болон Ерөнхийлөгчийн нэрэмжит тэмцээн, олон улс, улсын аварга шалгаруулах/ тэмцээнүүдэд гаргасан бол хүчин төгөлдөрт тооцно.

2.3. Төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч МЦСХ-ноос удирдан, зохион байгуулж, шүүж явуулсан тэмцээний хамрах хүрээ, үзүүлсэн амжилт, зэрэглэлийг харгалзан хүчин төгөлдөрт тооцож болно. Тэмцээнийг хүчин төгөлдөрт тооцох эсэх асуудлыг МЦСХ-ны удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

2.4. Цэрэгжлийн спортын тэмцээнүүдийг зохион байгуулж явуулах үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг чанд мөрдөж, гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх бүх шатны арга хэмжээг авсан байна.

2.5. Цэрэгжлийн спортын тэмцээнүүдийг стандартын дагуу баталгаажсан хэрэглэл, хэрэгслэл, материалыг ашиглан, аюулгүй байдлыг хангаж, тэмцээн явуулах орчныг бүрдүүлсэн заал, талбайд зохион байгуулна.

2.6. Цэрэгжлийн спортын тэмцээний төрлүүдэд оролцох эрх бүхий тамирчинд тавигдах шаардлагыг тухайн тэмцээнийг зохион байгуулах нэгдсэн заавар, удирдамжид зааж өгнө.

2.7. Цэрэгжлийн спортын тэмцээнүүдэд оролцох баг тамирчид, дасгалжуулагч нь тухайн төрлийн дүрэмд заагдсан зэвсэг, хэрэглэл, хувцаслалтын шаардлагыг хангасан байхаас гадна холбогдох баримт бичгийг бүрдүүлж биедээ байнга авч явна.

2.8. Баримт бичиг, дүрмэнд заагдсан зэвсэг, хувцас хэрэглэлийн зөрчилтэй байх нь баг, тамирчныг тэмцээнд оролцуулахгүй байх үндэслэл болно.

2.9. Цэрэгжлийн спортын тэмцээнүүдэд оролцох тамирчдад эрүүл мэндийн үзлэгт хамрагдах болон гэнэтийн ослын даатгалд даатгуулж, тэмцээнд оролцох баталгаа гаргасан байх шаардлага тавигдана.

2.10. Цэрэгжлийн спортын тэмцээнд оролцож байгаа багийн гишүүд нь зохион байгуулагч газраар батлагдсан зураг, нэр бүхий мандаттай байна.

2.11. Тэмцээнд оролцох багийн ахлагч, дасгалжуулагчид нь багийн бэлтгэлийг хангуулах, тэмцээнд оролцуулах асуудлыг бүрэн хариуцна.

2.12. Цэрэгжлийн спортын төрлүүдээр зохион байгуулагдах тэмцээнийг зөвхөн доорх тохиолдолд ерөнхий шүүгчийн шийдвэрээр зогсооно. Үүнд:

2.12.1. Тэмцээнийг санаачлан, зохион байгуулах байгууллагаас тодорхой шалтгааны улмаас тэмцээнийг хойшлуулах, зогсоох шийдвэр гаргасан;

2.12.2. Тэмцээн явуулах газар бэлтгэгдээгүй, зохион байгуулах боломжгүй;

2.12.3. Тэмцээнд ашиглах хэрэглэл, төхөөрөмжүүд байхгүй буюу дүрэмд зааснаар бэлтгэгдээгүй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй бол;

2.12.4. Цаг агаарын байдлаас шалтгаалан /харанхуй болох, хүчтэй шуурга, бороо, цас орох г.м/ тэмцээний ажиллагаанд саад болох бусад шалтгааны үед;

2.12.5. Тэмцээнд ашиглагдаж байсан техник, хэрэглэл, тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан буюу осол гарах нөхцөл бүрдсэн үед;

2.12.6. Тамирчид гэмтэл бэртэл авах, осолд өртсөн үед;

### **2.13. Шүүгчийн баг:**

2.13.1.Цэрэгжлийн спортын бүх төрлийн тэмцээн нь албан ёсны шүүгчийн багийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдана.

2.13.2.Зэвсэгт хүчний аварга шалгаруулах болон бусад албан ёсны тэмцээний ерөнхий шүүгч, шүүгчийн багийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилох ба бусад тэмцээнд зохион байгуулж байгаа байгууллагаас томилж болно.

2.13.3.Шүүгчийн багт ерөнхий шүүгч, нарийн бичиг шүүгч, ахлах шүүгч, шүүгч, эмч шүүгч, гараа, барианы шүүгч, цагчин /онооны/ шүүгч, техникийн шүүгч, замын шүүгч, нэвтрүүлэгч шүүгч, хяналтын шүүгч багтана.

2.13.4.Тэмцээнд цахилгаан ба механик тоног төхөөрөмж хэрэглэж байгаа үед шаардлагатай техникийн ажилтнуудыг шүүгчийн багт оролцуулна.

2.13.5.Шүүгчийн баг нь ижил өнгө, загварын таних тэмдэгтэй байна.

2.13.6.Шүүгчийн баг нь шударга, эрх тэгш, ил тод, бусдаас хараат бус байх зарчмыг баримтална.

2.13.7.Тэмцээнийг шүүн явуулж байгаа шүүх бүрэлдэхүүн нь оролцогчдод эмнэлгийн тусламжаас бусад ямар нэгэн тусламж үзүүлэхийг хориглоно.

2.13.8.Маргаантай асуудлыг шийдэх үед шүүгчийн багийн санал зөрөлдсөн тохиолдолд олонхийн саналаар батлана.

2.13.9.Тэмцээний үед сахилга, ёс зүй, дүрмийн алдаа гаргасан тамирчин, дасгалжуулагчид сануулах, торгох зорилгоор шүүгчийн картыг хэрэглэхийг тэмцээний ахлах шүүгч, шүүгчдэд зөвшөөрнө.

2.13.10.Шүүгчийн багт томилогдсон шүүгч нар нь ерөнхий болон ахлах шүүгчийн зөвшөөрөлгүйгээр тэмцээн зохион байгуулах журмыг зөрчих, тэмцээний байрлалыг орхин явахыг хориглоно.

2.13.11.Тэмцээнд оролцох багийн дасгалжуулагч ба багийн ахлагч нь тухайн тэмцээнийг явуулах шүүгчийн багийн гишүүн байж болохгүй.

### **2.14. Ерөнхий шүүгч:**

2.14.1.Ерөнхий шүүгч нь шүүгчийн багийн ахлагч бөгөөд тэмцээнийг удирдан зохион байгуулагч байна. Түүний тэмцээнтэй холбоотойгоор гаргасан шийдвэр эцсийн шийдвэр байна.

2.14.2.Ерөнхий шүүгч дараах эрхийг эдлэнэ. Үүнд:

2.14.2.1.Тэмцээний дүрэм, зааварт заагдаагүй учирсан тохиолдолын талаар зохион байгуулах нөхцөлийг өөрчлөхгүйгээр шийдвэр гаргах;

2.14.2.2.Тэмцээнийг зохион байгуулах журманд өөрчлөлт оруулах, эхлэх хугацааг хойшлуулах, эхэлсэн үед зогсоох буюу түр завсарлуулах;

2.14.2.3.Тэмцээний тухайн төрлийн дүрмийн шаардлага хангаагүй оролцогчдыг тэмцээнд оролцуулахгүй байх;

2.14.2.4.Ёс зүйн зөрчил гаргасан, техникийн бэлэн бус, биеийн хүчний бэлтгэл хангагдаагүй тамирчдыг тэмцээнийг цааш үргэлжлүүлэхийг хориглох;

2.14.2.5.Тэмцээний үед дүрэм зөрчсөн болон үүргээ биелүүлж чадахгүй байгаа шүүгчийг өөрчлөх, солих, чөлөөлөх;

2.14.2.6.Гаргасан шийдвэр, үйлдэл нь буруу нь батлагдсан тохиолдолд шүүгчийн гаргасан шийдвэрийг өөрчлөх;

2.14.2.7.Өөрийнхөө үүргийг биелүүлж чадахгүй байгаа буюу ноцтой зөрчил гаргасан багийн ахлагч ба дасгалжуулагчдад анхааруулах, сахилгын

шийтгэл оногдуулах саналыг холбогдох байгууллагад оруулах;

2.14.2.8. Тэмцээнтэй холбоотойгоор эцсийн шийдвэр гаргах;

2.14.3. Ерөнхий шүүгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.14.3.1. Тэмцээн явуулах болон шүүгчийн хуваарь, тэмцээн зохион байгуулах журмыг тогтоож, баг, тамирчдад тайлбарлах;

2.14.3.2. Тэмцээн зохион байгуулах газрыг тогтоох, зай хэмжилт хийх, багаж хэрэгслэл, хэрэгсэл, тоног төхөөрөмж нь дүрмийн дагуу бэлтгэгдсэн эсэхэд хяналт тавих, хүлээн авч, шалгах;

2.14.3.3. Тэмцээнд оролцогчид, үзэгчид, багийн ахлагчид, радио, телевиз болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг хэрэгцээтэй мэдээллээр хангах;

2.14.3.4. Тэмцээний үед гарсан гомдол буюу үл ойлголцлыг шийдэх;

2.14.3.5. Тэмцээний үед тогтоосон дээд амжилтыг батлах хяналт тавих;

2.14.3.6. Тэмцээний талаарх хуралдааныг тэмцээн эхлэхээс өмнө, тэмцээний явц, тэмцээн дууссаны дараа зохион байгуулах;

2.14.3.7. Тэмцээн зохион байгуулсан тайланг бичгээр гаргуулж, батлан холбогдох газарт хүргүүлэх;

## **2.15. Тэмцээний нарийн бичгийн дарга шүүгч:**

2.15.1. Тэмцээний нарийн бичгийн дарга нь ерөнхий шүүгчид захирагдана.

2.15.2. Тэмцээний нарийн бичгийн дарга нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.15.2.1. Шүүгчийн багийн ажил үүргийн хуваарийг гаргах, зохион байгуулах;

2.15.2.2. Мэдүүлэг авах, сугалаа сугалуулах, тэмцээний хуваарийг гаргах;

2.15.2.3. Тэмцээний протокол хөтлөх, оролцогчдод хүргэх;

2.15.2.4. Тэмцээний төрөл, хэсгүүдийг хянан зааварлах;

2.15.2.5. Өөрсдийн ажлыг мэдээллийн төвийн удирдлагатай холбох;

2.15.2.6. Тэмцээний дүнгийн хүснэгтийг бэлтгэх, дүнг нэгтгэх,

2.15.2.7. Тэмцээний дүнг ерөнхий шүүгч, баг тамирчдад мэдээлэх;

2.15.2.8. Цол, зэргийн шаардлага хангасан тамирчдыг тодруулах;

2.15.2.9. Тэмцээний протоколыг хянах, тамирчдын байрыг тодорхойлох;

2.15.2.10. Тэмцээний үр дүнгийн тайлан гаргах;

## **2.16. Төрөл, талбай хариуцсан ахлах шүүгч:**

2.16.1. Ахлах шүүгч нь ерөнхий шүүгч, нарийн бичиг шүүгчид шууд захирагдах ба түүний удирдлаган дор тэмцээний тухайн төрлийн хэсгийг удирдан зохион байгуулж явуулна.

2.16.2. Ахлах шүүгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.16.2.1. Тэмцээн эхлэхээс өмнө тухайн төрлийн тэмцээний байр, талбайг шалгаж, тэмцээний хэрэглэл, хэрэгсэл, талбайн шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах, шаардлагатай бол зөрчлийг арилгуулах;

2.16.2.2. Тэмцээний үйл ажиллагааг хэвийн явуулахад хяналт тавьж, дүрмийн дагуу удирдан зохион байгуулж, баг, тамирчдад мэдээлэл өгөх;

2.16.2.3. Тэмцээний дүрэм, журам зөрчигдсэн талаар маргаантай асуудлыг хүлээн авч шийдвэрлэх, энэ тухай ерөнхий шүүгчид санал оруулах;

2.16.2.4. Ахласан хэсгийн сахилга дэг журмыг мөрдүүлж, өөрийнхөө шийдвэрийн бодит байдлыг хариуцах;

**2.17. Шүүгч:**

2.17.1. Шүүгч нь ерөнхий шүүгч, ахлах шүүгчид захирагдана.

2.17.2. Шүүгч нь шударга, эрх тэгш, ил тод, бусдаас хараат бус байх зарчмыг баримталж, ёс зүйн хэм хэмжээг мөрдөнө.

2.17.3. Шүүгч нь тэмцээний дүрэм, журмыг сайтар судалсан байх үүрэгтэй.

2.17.4. Шүүгч нь баг, тамирчдын амжилтыг дүрмийн дагуу үнэн зөв дүгнэн, цаг тухайд нь мэдээллэж байх үүрэгтэй.

2.17.5. Тэмцээнийг эхлүүлэхээс өмнө талбай, хэрэглэл, хэрэгслэлийн бүрэн бүтэн байдал, бэлтгэгдсэн эсэхэд хяналт тавих, шаардлагатай бол зөрчлийн арилгуулахаар шаардах эрхтэй.

2.17.6. Тэмцээнд оролцогч баг, тамирчдад тэмцээний дүрэм, зохион байгуулах журмын дагуу шаардлага тавьж, биелэлтийг шаардах эрхтэй.

2.17.7. Тэмцээний үед зөрчил гарсан тохиолдолд тэмцээний дүрэм, зохион байгуулах журмын дагуу торгууль оногдуулах, шүүгчийн картыг хэрэглэх эрхтэй.

2.17.8. Тэмцээнтэй холбоотойгоор ерөнхий шүүгч, ахлах шүүгчид санал оруулах, шийдвэрлүүлэх эрхтэй.

**2.18. Техникийн шүүгч:**

2.18.1. Материал, техникийн хангалтын хэсгийг ахалж, тэмцээний явцыг хянах, бэлтгэл хийх, тэмцээнийг зохион байгуулах газар, талбайг бэлтгэх ажлыг хариуцан ажиллана.

2.18.2. Тэмцээн зохион байгуулах заал, зам, талбай, хэрэглэл, хэрэгслэл, тоног төхөөрөмжүүдийг бэлтгэх, техникийн үзлэг, замын хэмжилт, тэмдэглэгээнүүдийг хийх, тэдгээрийг ашиглах тухай баталгаа гаргах үүрэгтэй.

2.18.3. Тамирчин гэмтэл, бэртэл авсан тохиолдолд бүх хэрэглэл, хэрэгсэлд техникийн аюулгүй байдлын акт тогтоож, шалтгааныг тодруулах үүрэгтэй.

2.18.4. Тэмцээн зохион байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, онооны самбар, дохиоллын хэрэгслүүд, холбоо, цахилгаан мэдээллийн хэрэгсэл, туг өргөх, чанга яригч, өсгөгч, мэдээллийн дэлгэц, шагналын тавцан шүүгчийн багийн ажиллах байрыг бэлтгэх, бичиг хэрэг, бусад мэдээллийн материалуудыг олшруулах хэрэгслээр хангах үүрэгтэй.

**2.19. Гараа, барианы шүүгч:**

2.19.1. Гарааны шүүгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.19.1.1. Тэмцээний төрөл, хэсгүүдийн ахлах шүүгч болон шүүгчдийн бэлэн болсон, тамирчин гараан дээр зөв байрлал эзэлсэн эсэхийг нягтлах, бэлэн болсны дараа тэмцээнийг эхлүүлэх;

2.19.1.2. Эхлэх дохиог тамирчдад мэдэгдэхүйцээр, ойлгомжтой хэлбэрээр /тусгай зориулалтын буу буюу тугаар/ өгөх;

2.19.1.3. Хоёр буюу түүнээс дээш тамирчид оролцох үед дохио өгөхдөө тамирчдыг ижил нөхцөлд байрлуулсан байх;

2.19.1.4.Тамирчин эхлэх дохио өгөхөөс өмнө үйлдэл хийсэн бол тэмцээний гарааг зогсоож, дүрмийн дагуу арга хэмжээ авч дахин эхлүүлэх;

2.19.1.5.Ээлжит тамирчдыг гараанд бэлтгүүлэн, дүрмийн дагуу үзлэгийг явуулж, баримт бичгийн шалгаж, тэмдэглэл хөтлөх;

2.19.2.Барианы шүүгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.19.2.1.Тамирчдын амжилтыг төрлийн дүрмэнд заасны дагуу үнэн, зөв бүртгэж, баг, тамирчдад ил тодоор мэдээлэх;

2.19.2.2.Тамирчид барианд орохдоо дасгалыг зөв, дүрмийн дагуу бүрэн гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлох;

2.19.2.3.Тамирчдын дасгал гүйцэтгэсэн талаар замын буюу хяналтын шүүгчдийн дүнг авч тэмцээн амжилттай болсон эсэхийг тодорхойлох;

2.19.2.4.Тэмцээний маргаантай асуудлаар гаргасан гомдол, саналыг гарын үсгээр баталгаажуулж ахлах шүүгчид өгч шийдвэрлүүлэх;

## **2.20. Замын буюу хяналтын шүүгч:**

2.20.1.Замын буюу хяналтын шүүгч нь дүрэм зөрчсөн байдлыг барианы шүүгчид, техник хэрэгслийн бэлэн байдлын тухай гарааны шүүгчид мэдээллэнэ.

2.20.2.Замын буюу хяналтын шүүгч нь гараа, барианы шүүгчид харагдаж байхаар байрлах ба замын нөхцөлөөс шалтгаалан харагдахгүй байх үед гар станц болон бүх боломжийг ашиглан мэдээллийг цаг тухайд нь дамжуулна.

2.20.3.Замын буюу хяналтын шүүгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.20.3.1.Талбайд тавигдсан багаж, хэрэгсэл, тэмдэглэгээг шалгах;

2.20.3.2.Тамирчдын дасгалын гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх;

2.20.3.3.Дасгал гүйцэтгэж байгаа тамирчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл ерөнхий шүүгчид мэдээллэх;

2.20.3.4.Тэмцээний үед техник, хэрэгсэл эвдэрсэн буюу техник аюулгүйн байдал алдагдсан тохиолдолд ерөнхий шүүгчид мэдэгдэн, арга хэмжээ авах;

## **2.21. Цагчин /онооны/ шүүгч:**

2.21.1.Цагчин /онооны/ шүүгч нь тамирчны авсан оноо, амжилтын хугацааг хэмжиж, алдаагүй, үнэн зөв тэмдэглэнэ.

2.21.2.Цагчин /онооны/ шүүгчийн ажлыг ерөнхий шүүгчийн шийдвэрээр гараа, барианы шүүгч давхар гүйцэтгэж болно.

2.21.3.Цагчин шүүгч нөөц секундомертэй байна.

2.21.4.Тэмцээн эхлэхээс өмнө секундомер болон хэмжих багажийг шалгаж, тэмцээн эхлүүлэхэд бэлэн байгаа талаар дохио өгнө.

2.21.5.Цагчин шүүгч нь өөрийнхөө секундомерийн үзүүлэлтийг /бусадтай ярилцахгүйгээр/ ахлах шүүгчид мэдээллэнэ.

2.21.6.Секундомерийн үзүүлэлтийн тухай санал зөрсөн тохиолдолд эцсийн шийдвэрийг ахлах шүүгч гаргана.

2.21.7.Хугацааг тэмдэглэсний дараа цагчин шүүгч нь секундомерийн заалтыг зөвхөн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр 0:00:00,00 болгоно.

2.21.8.Цагчин /онооны/ шүүгч нь тэмдэглэлд оноо болон дүнг алдаатай бичсэн тохиолдолд арилгахгүйгээр дээрээс нь ганц зурж, хажууд нь зөв амжилтыг бичиж, ахлах шүүгчийн гарын үсгээр баталгаажуулна. Энэ тухай

баг, тамирчинд мэдэгдэнэ.

2.21.9.Тэмцээний тухайн төрлийн хөтөлбөр дуусангуут ахлах шүүгчийн баталгаат гарын үсэгтэй тэмдэглэлийг нарийн бичиг шүүгчид өгнө.

#### **2.22. Эмч шүүгч:**

2.22.1.Тэмцээний эмч шүүгч нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

2.22.1.1.Тэмцээний мэдүүлэг өгөх үед оролцогчдын эрүүл мэндийн үзлэгийн баримт бичгийн зөв эсэхийг шалгах;

2.22.1.2.Тэмцээнд эрүүл мэндийн хувьд тэнцсэн тамирчдыг оруулах, тэмцээний үед тамирчдын эрүүл мэндэд хяналт тавих;

2.22.1.3.Тэмцээний туршид оролцогч тамирчдад эмнэлэгийн хяналт тавьж, өвдөлт, гэмтэл авсан, тэмцээнийг үргэлжлүүлэх боломжгүй болсон тамирчдыг тэмцээнээс чөлөөлөх асуудлыг ерөнхий шүүгчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;

2.22.1.4.Тэмцээнийг зохион байгуулах үеийн эмнэлэг, ариун цэврийн байдлыг шалгах, шаардлагатай үед эмнэлэгийн тусламж үзүүлэх;

2.22.1.5.Тэмцээний төгсгөлд ерөнхий шүүгч буюу тэмцээн зохион байгуулж буй байгууллагад эмнэлэг, ариун цэврийн дүгнэлт, тайлан гаргах;

2.22.1.6.Тамирчдын талаарх эмнэлэгийн дүгнэлтийг үнэн зөв гаргаж, өөрийнхөө шийдвэрийн бодит байдлыг хариуцах;

#### **2.23. Нэвтрүүлэгч шүүгч:**

2.23.1.Цэрэгжлийн спортын бүх төрлийн тэмцээнүүдэд нэвтрүүлэгч шүүгч томилогдон ажиллана. Нэвтрүүлэгч шүүгч нь тэмцээний дүрэм, хөтөлбөрийг судалсан байх үүрэгтэй.

2.23.2.Нэвтрүүлэгч шүүгч нь нэвтрүүлэг хөтлөж, цэрэгжлийн спорт, оролцогч баг, тамирчдыг олон нийтэд сурталчилах үүрэгтэй.

2.23.3.Нэвтрүүлэгч шүүгч нь тэмцээний явц, дүн, амжилтын талаар цаг тухайд нь олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

#### **2.24. Шүүгчийн шар, улаан карт:**

2.24.1.Цэрэгжлийн спортын тэмцээнүүдэд ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан, шүүгчийн шаардлагийг биелүүлээгүй, дүрэм, заавар зөрчсөн тамирчин, дасгалжуулагч, багийн ахлагчийг сануулах, тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авах үед шүүгчийн картыг хэрэглэнэ.

2.24.2.Шүүгчийн картыг тэмцээний ерөнхий шүүгч, ахлах шүүгч, тухайн талбайд тэмцээнийг удирдан явуулж байгаа шүүгч эдлэх эрхтэй.

2.24.3.Шүүгчийн картыг тухайн тэмцээн эхлэхээс, дуусах хүртлэх хугацаанд ашиглахыг зөвшөөрнө. Бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

2.24.4.Шүүгчийн карт нь шар, улаан өнгөтэй байна.

2.24.5.Шүүгчийн картыг шар, улаан гэсэн дарааллын дагуу доорх байдлаар ашиглана. Үүнд:

2.24.5.1.Шар карт: Зөрчил гаргасныг анхааруулах;

2.24.5.2.Улаан карт: Тэмцээнээс хасах;

#### **2.25. Дасгалжуулагч ба багийн ахлагч:**

2.25.1.Тэмцээнд оролцогч баг нь албан ёсны багийн ахлагч болон

дасгалжуулагчтай байна. Багийн ахлагч, дасгалжуулагч нь өөрийн багийн өмнө хариуцлага хүлээх бүрэн чадвартай байна.

2.25.2.Багийн ахлагч, дасгалжуулагч нар тэмцээний явцад зохион байгуулж буй шүүгчийн шийдвэрт оролцох, нөлөөлөхийг хориглоно.

2.25.3.Багийн ахлагч болон гишүүд нь тэмцээн бүрэн дуусаагүй буюу тухайн өдрийн тэмцээний үр дүн гараагүй байхад тэмцээнийг орхиж явахыг хориглоно.

2.25.4.Багийн амжилтыг ахиулах зорилгоор мэдүүлгэнд тусгагдаагүй тамирчныг оролцуулахыг хориглоно.

2.25.5.Багийн ахлагч, дасгалжуулагч нь дараах эрхтэй. Үүнд:

2.25.5.1.Тэмцээний талаарх мэдээллийг шүүгчийн багаас, тэмцээний үр дүнгийн тухай мэдээллийг нарийн бичиг шүүгчээс авах;

2.25.5.2.Баг, тамирчдыг төлөөлж мэдүүлэг өгөх, сугалаанд оролцох;

2.25.5.3.Багийнхаа нэрийн өмнөөс мэдээлэл өгөх, санал гаргах, дүрмийн дагуу саналаа илэрхийлэх, гомдол гаргах;

2.25.6.Багийн ахлагч, дасгалжуулагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

2.25.6.1.Багийн ахлагч, дасгалжуулагч нь тухайн тэмцээний дүрэм, журмыг судлаж, түүнийг удирдлага болгон хэрэгжүүлэх;

2.25.6.2.Тамирчныг тэмцээнд оролцох үед аюулгүй байдлыг хангаж, тусламж, хамгаалалтыг хийх;

2.25.6.3.Тэмцээний шүүгчийн багийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

2.25.6.4.Баг, тамирчдыг тэмцээн болох газар бэлэн байлгах, албан ёсны нээлт болон хаалтын үйл ажиллагаанд багийг удирдан, оролцуулах;

2.25.6.5.Баг, тамирчдын хувцаслалтыг дүрмийн дагуу хэрэглүүлэх;

2.25.6.6.Тэмцээний техникийн зөвлөлгөөний хуралд биечлэн оролцох;

2.25.6.7.Шүүгчийн гаргасан шийдвэрийг тамирчдад бүрэн хүргэх;

## **2.26. Тэмцээнд оролцогч тамирчин:**

2.26.1.Цэрэгжлийн спортын тэмцээнд оролцох тамирчин нь өөрийн оролцох тухайн төрлийн тэмцээний дүрэм, зохион байгуулах зааврын бүх нөхцөл болзолыг судлан, хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр оролцоно.

2.26.2.Тэмцээнд оролцогч тамирчин нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

2.26.2.1.Тэмцээний дүн, амжилтын талаар багийн ахлагч, дасгалжуулагчаар дамжуулан мэдээлэл авах;

2.26.2.2.Тэмцээний талаар хүсэлт гомдолыг багийн дасгалжуулагч, ахлагчаар дамжуулан гаргах;

2.26.2.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах;

2.26.3.Тэмцээнд оролцогч тамирчин нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

2.26.3.1.Тухайн төрлийн тэмцээний дүрмийг сайтар судалсан байх;

2.26.3.2.Тамирчин нь тэмцээний шаардлагын дагуу эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх;

2.26.3.3.Шүүгчийн багийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

2.26.3.4.Баг, тамирчид нь тухайн төрлийн дүрмэнд заагдсан зориулалт бүхий өмсгөл, хувцас, хэрэглэлийн шаардлагыг хангасан байх;

2.26.3.5.Тэмцээний нээлт, хаалт болон шүүгчийн удирдлагын дор нийтээр зохион байгуулалттай явагдаж байгаа үйл ажиллагаанд оролцох;

2.26.4.Багийн амжилтыг ахиулах зорилгоор өөр тамирчны нэр дээр

дасгал боловсруулах, бусдын баримт бичгийг ашиглахыг хатуу хориглоно. Энэ зөрчил гаргасан тамирчныг тэмцээнээс хасч дүрэм, зааврын дагуу арга хэмжээ авна.

### **2.27. Хүсэлт, гомдол гаргах:**

2.27.1. Тэмцээнд оролцогч баг, тамирчид нь маргаантай асуудлаар ерөнхий шүүгчийн нэр дээр хүсэлт, гомдлыг гарган шалгуулж, шийдвэрлүүлэх эрхтэй.

2.27.2. Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн баг, тамирчныг төлөөлөх эрхтэй дасгалжуулагч эсвэл багийн ахлагч бичгээр үйлдэн тэмцээний нарийн бичгийн даргаар дамжуулан ерөнхий шүүгчид гаргана.

2.27.3. Гаргасан хүсэлт, гомдол нь үндэслэлтэй, баримттай байх бөгөөд шалгуулах, шийдвэрлүүлэх асуудал, өөрийн хаягыг тодорхой бичиж, гарын үсэг зурсан байна.

2.27.4. Тэмцээний талаарх зөрчлийг шалгуулах хүсэлтийг тухайн тамирчин гараанаас гарах, дасгал гүйцэтгэх эхлэхээс өмнө гаргана.

2.27.5. Тэмцээний үр дүнгийн талаарх гомдол, хүсэлтийг тэмцээний нэгдсэн дүн танилцуулагдахаас өмнө гаргана.

2.27.6. Шүүгчийн баг доорхи тохиолдолд гаргасан хүсэлт, гомдлыг хүлээж авахгүй. Үүнд:

2.27.6.1. Хөгжөөн дэмжигч, хувь хүн болон тамирчны гаргасан;

2.27.6.2. Бичгээс бусад хэлбэрээр гаргасан;

2.27.6.3. Хүсэлт, гомдол гаргагчийн нэр, хаяггүй ирүүлсэн;

2.27.6.4. Тодорхой үндэслэл, нотлох баримтгүй;

2.27.6.5. Тэмцээний ерөнхий дүн гарсанаас хойш;

2.27.7. Шүүгчийн баг нь маргаантай асуудлыг ерөнхий шүүгч, нарийн бичгийн дарга, тухайн талбайн ахлах шүүгч, шүүгч, гомдол гаргасан болон эсрэг багийн дасгалжуулагч нарыг байлцуулан тэмцээний дүн батлагдаж, танилцуулахаас өмнө илтээр авч хэлэлцэн шийдвэрийг гаргана.

### **2.28. Дээд амжилтыг бүртгэх:**

2.28.1. Цэрэгжлийн спортын тэмцээний дүрмийн дагуу явагдсан Зэвсэгт хүчний аварга шалгаруулах болон МЦСХ-ноос зохион байгуулсан улс, бүсийн албан ёсны тэмцээн дээр давтсан буюу шинэчлэн тогтоосон амжилтыг дээд амжилт гэж тооцно.

2.28.2. Дээд амжилтыг өмнөх оролцогчийн амжилтаас хугацаагаар хэмжих төрөлд 0.01 секунд, тоогоор хэмжих төрөлд 0,01 оноо илүү тохиолдолд тооцно.

2.28.3. Тэмцээний дүрмийн шаардлага хангасан техник, хэрэглэл, тоног төхөөрөмж, зам, талбайд үзүүлсэн амжилтыг албан ёсны дээд амжилтаар бүртгэнэ.

2.28.4. Шүүгчийн баг тэмцээний материалыг шалгаж, тамирчны үзүүлсэн дээд амжилтыг баталгаажуулна.

2.28.5. Хэрэв нэг тэмцээн дээр 2 болон түүнээс дээш тамирчин 1 ижил дээд амжилт үзүүлбэл, тэдний тэмцээнд эзэлсэн байраас хамаарахгүйгээр дээд амжилт тогтоосонд тооцож, бүртгэлд тамирчдын нэрийг амжилт тогтоосон дарааллаар бичнэ.

2.28.6.Цэрэгжлийн спортын цол, зэргийн ангиллын нормативыг биелүүлсэн бол шагналт байр харгалзахгүйгээр “Цэрэгжлийн спортын цол, зэрэг олгох журам”-ын дагуу холбогдох байгууллагад цол, зэргийг олгуулахаар тодорхойлно.

#### **2.29. Техникийн зөвлөлгөөн:**

2.29.1.Цэрэгжлийн спортын тэмцээнүүдийн техникийн зөвлөлгөөнийг тэмцээн зохион байгуулах заавар, удирдамжид заасан газар, хугацаанд хийнэ.

2.29.2.Тэмцээний техникийн зөвлөлгөөнд албан ёсоор томилогдсон албан тушаалтан, багийн дасгалжуулагч, ахлагч нар оролцох ба тэмцээн байгуулах зааварт заасан холбогдох баримт бичгийг бүрдүүлж авчирна.

2.29.3.Тэмцээний техникийн зөвлөлгөөнд оролцоогүй, мэдүүлэг гаргаагүй, сугалаанд хамрагдаагүй баг, тамирчдыг тэмцээнд оролцуулахгүй.

2.29.4.Тодорхой хүндэтгэх шалтгааны улмаас техникийн зөвлөлгөөнд биеэр оролцох боломжгүй багийн ахлагч, дасгалжуулагч нь техникийн зөвлөлгөөн эхлэхээс өмнө ерөнхий шүүгчид албан ёсоор мэдэгдэнэ.

## **Гуравдугаар бүлэг.**

### **ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИК**

3.1. Цэрэгжлийн гимнастикийн тэмцээн нь модон моринд малгай тавьж харайх, сонс эргэх, олон төрөлт гэсэн төрлүүдээр зохион байгуулагдана.

3.2. Тэмцээний бүх төрөлд оролцож байгаа тамирчин талбайн эхлэх байранд ирээд номхон зогсож, баруун гарыг шулуун дээш өргөн бэлэн болсноо мэдэгдэн шүүгчийн зөвшөөрлөөр дасгалыг гүйцэтгэж дуусмагц номхон зогсож, баруун гарыг шулуун дээш өргөн дууссан тухайгаа мэдэгдсэнээр гүйцэтгэлийг тооцно.

3.3. Хувцас, хэрэглэл, баримт бичгийн зөрчилтэй байх нь тамирчныг тэмцээний талбайд гаргахгүй байх, тэмцээнээс хасах үндэслэл болно.

#### **3.4. Багийн бүрэлдэхүүн.**

3.4.1. Тэмцээнд оролцох нэг баг нь модон моринд малгай тавьж харайх төрөлд эрэгтэй 2 тамирчин, сонс эргэх төрөлд оролцох эрэгтэй 2 тамирчин, олон төрөлтөд оролцох эрэгтэй 2 тамирчин, эмэгтэй 1 тамирчин, нийт 7 хүртэлх тамирчнаас бүрдэнэ.

3.4.2. Тэмцээнд шаардлага хангасан, тухайн тэмцээнийг зохион байгуулах заавар, удирдамжаар зөвшөөрөгдсөн хүн бүр оролцож болно.

3.4.3. Олон төрөлтөд оролцох эрэгтэй тамирчин сонс эргэх, модон моринд малгай тавьж харайх төрлийн аль нэгэнд оролцохыг зөвшөөрнө.

3.4.4. Сонс эргэх төрөлд оролцсон тамирчин модон моринд малгай тавьж харайх төрөлд, модон моринд малгай тавьж харайх төрөлд оролцсон тамирчин сонс эргэх төрөлд оролцохыг зөвшөөрөхгүй.

### **3.5. Хувцаслалт.**

3.5.1. Дасгалжуулагч нь тэмцээний үед спорт хувцас, гуталтай байна.

3.5.2. Цэрэгжлийн гимнастикийн тэмцээнд оролцох тамирчин нь өвдөг, тохой ил гарч бие барьсан, гэрэлтдэггүй спорт өмд /шорт/, майк, эмэгтэй тамирчид бие барьсан, хагас ханцуйтай фудболктой, модон моринд малгай тавьж харайх төрлөөс бусад төрөлд цагаан өнгийн спорт оймстой байна. Зөвхөн тэмцээний ерөнхий шүүгчийн зөвшөөрснөөр хөл нүцгэн байж болно.

3.5.3. Модон моринд малгай тавьж харайх төрөлд оролцох тамирчин 1 см-ээс хэтрэхгүй зузаантай резинэн ултай, спорт гуталтай байна.

3.5.4. Цэрэгжлийн гимнастикийн тэмцээнийг гадаа талбайд зохион байгуулах үед төрөл харгалзахгүй бүх тамирчид спорт гуталтай байна.

3.5.5. Тэмцээнд оролцож байгаа тамирчид 25x15 см-ээс багагүй хэмжээтэй хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг тамирчны нуруунд байрлуулсан байна.

3.5.6. Цэрэгжлийн гимнастикийн тэмцээнд оролцох тамирчин нь гар хөлийн үе болон биедээ эмчилгээний зориулалттай наалтнаас бусад нэмэлтээр хамгаалалтын хэрэглэл, бүс, боолт хийхийг хориглоно.

3.5.7. Сонс эргэх тамирчин нь гарын алга хамгаалах зориулалтаар бүх хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлий, боолт хийх, шуунд хамгаалалтын боолт хийхийг ерөнхий шүүгчийн шийдвэрээр зөвшөөрч болно.

3.5.8. Сонс эргэх төрөлд оролцох тамирчин 2 гартаа зориулалтын бэхэлгээтэй байна. Бэхэлгээ нь 2 см-ээс нарийнгүй, 0,2 см-ээс дээш зузаантай, уртааш нь 3-4 эгнээ ширж оёсон, хоёр үзүүрийг мушгаруулалгүй 3-5 см зөрүүлж, 45 градусын налуугаар 3-4 эгнээ дөрвөлжлөн ширж оёсон, сунадаггүй даавуун материалаар хийгдсэн байна.

3.5.9. Гимнастикийн хэрэглэл дээр дасгал гүйцэтгэх үед гарын алга болон биед зуурах чанарыг сайжруулж, уналтаас сэргийлэх зорилгоор спортын зориулалтын цагаан нунтаг буюу шохой /магнез/-г хэрэглэхийг зөвшөөрнө.

### **3.6. Хэрэглэл, тоног төхөөрөмж.**

3.6.1. Тэмцээний заалны талбай нь ашиглагдах бүх хэрэглэлийг байрлуулж багтаасан, бие халаалтын талбай, эмч, сурвалжлагч, тамирчид, дасгалжуулагчдын суудлын хэсэг орсон багтаамжтай байна.

3.6.2. Тэмцээнд ашиглагдах дүүжин, суга савлуур, модон морь нь гимнастикийн хэрэглэлд тавигдах шаардлагын дагуу баталгаажсан байхаас гадна хоорондын аюулгүй зай, хэмжээг баримталсан байна.

3.6.3. Гэрэлтүүлэг /байгалийн болон зохиомол/ нь тамирчдын нүдийг гялбуулахгүйгээр туссан байна.

3.6.4. Хамгаалалтын матраснуудыг хөдөлгөөнгүй байхаар байрлуулна.

3.6.5. Хэрэглэл бүрт аюулгүй байдлыг бүрэн хангахуйцаар нэмэлт матрасыг байрлуулсан байна. Нэмэлт матрас нь хэрэглэлийн суурийг тэгш бүрхсэн, өргөн ба уртын хэмжээ нь хэрэглэл бүрийн онцлогт тохирсон стандарт хэмжээтэй байна.

3.6.6. Хайралтын төрлийн хэрэглэл:

3.6.6.1. Харайлтын модон морь нь 160 см урт, 120 см өндөр, 35 см өргөн хэмжээтэй байна.

3.6.6.2. Харайлтын гүйлтийн зам нь 2000-2500 см урт, 100 см өргөн, резинэн материалаар хийгдсэн, түлхэлтийн бандангаас ялгагдахуйц өнгөтэй, шалтай зууралдсан, гулгахгүй байхаар байрласан байна.

3.6.6.3. Түлхэлтийн бандан 120 см урт, 60 см өргөн, 20 см-ээс өндөргүй хэмжээтэй гүйлтийн замаас ялгагдахуйц өнгөтэй, нумарсан хэлбэртэй байна.

3.6.6.4. Харайлтын төрлийн газарталтын матрасс нь 600x200 см хэмжээтэй 20 см-ээс багагүй зузаантай байна.

3.6.7. Чөлөөт хөдөлгөөний талбай:

3.6.7.1. Чөлөөт хөдөлгөөний талбай нь тэгш, зөөлөн, эргэлт, гулссан хөдөлгөөн хийхэд зууралдахгүй, арьсыг гэмтээхгүй байна

3.6.7.2. Чөлөөт хөдөлгөөний талбай нь 1200 см урт, 200 см өргөнтэй, 5 см-аас доошгүй зузаантай, хивс, хивсэнцэр гадаргуутай байна.

3.6.7.3. Чөлөөт хөдөлгөөн гүйцэтгэх талбайн эргэн тойронд 200 см өргөнтэй аюулгүйн бүсийн талбайг хивс, хивсэнцэр материалаар төхөөрөмжилнө.

3.6.8. Суга савлуур:

3.6.8.1. Суга савлуур нь 350 см урт, 180 см-ээс дээш өндөртэй, төмөр голтой, модон материалаар хийгдсэн хөндлөвчтэй, хөндлөвч хоорондын зай 42-52 см байна.

3.6.8.2. Суга савлуурын талбайн нь 400x400 см хэмжээтэй байна.

3.6.9. Дүүжин:

3.6.9.1. Дүүжин нь 240 см өргөн, 280 см өндөр, хөндлөвчийн диаметр 2,8 см, хийц нь ган, цул төмөр байна.

3.6.9.2. Дүүжингийн татлага нь аюулгүй байдлыг хангасан, троссны ширхэг тасраагүй, стандарт шаардлагад нийцсэн байна.

3.6.9.3. Дүүжингийн төрлийн талбайн нь 400x400 см хэмжээтэй байна.

**3.7. Модон моринд малгай тавьж харайх төрөл:**

3.7.1. Модон морин дээр цэргийн өвлийн малгайн хэмжээтэй загваруудыг давхарлан тавьж дээгүүр нь давж харайх дасгалыг гүйцэтгэнэ.

3.7.2. Нэг малгайн хэмжээ нь 12 см өндөр, 20-25 см диаметрийн хэмжээтэй, цэргийн өвлийн малгайны хэлбэртэй, парлонон материалаар хийгдсэн байна.

3.7.3. Харайлтыг зориулалтын түлхэлтийн бандан /ратер/ ашиглан гүйцэтгэнэ.

3.7.4. Тамирчин урьдчилан захиалга өгөх бөгөөд хамгийн бага захиалгыг өгсөн тамирчнаас эхлэн сугалааны дарааллаар дасгалыг гүйцэтгүүлнэ. Тамирчин дахин захиалга өгөхгүй, малгайн нэмэгдэх дарааллаар дасгалыг цааш үргэлжлүүлнэ.

3.7.5. Малгайн загварыг үсрэлтийн бандан байрлах талд, модон морины захаас 20 см зайд өрж байрлуулна. Өрсөн малгай босоо тэнхлэгт, тэгш байрлана.

3.7.6. Модон моринд малгай тавьж харайх дасгал нь урьдчилсан гүйлтээс харайлтын банданд шилжиж түлхэлт аван үсэрч малгайн дүрс дээгүүр босоо тэнхлэгийн дагуу харайлтыг гүйцэтгээд босоо байдлаа хадгалан хоёр хөл дээр буултыг хийн баруун гарыг дээш өргөж цэх зогссоноор дуусна. Буух үед гараар тулах, тэнцвэр алдан хагас суух, алхамт хийхийг зөвшөөрнө.

3.7.7. Нэг захиалга дээр 3 оролтыг зөвшөөрнө. Дасгал амжилтгүй болсон тохиолдолд боломжит оролдлогийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

3.7.8. Тамирчин урьдчилсан гүйлтээс түлхэлтийн тавцан, модон моринд хүрэлгүйгээр сул гүйснийг оролдлогод тооцохгүй. Дахин гүйцэтгэхийг зөвшөөрнө.

3.7.9. Модон морины хажууд 1 шүүгч, харайх чиглэлийн дагуу дасгал гүйцэтгэж байгаа тамирчин эгц урдаас харагдаж байхаар 1 шүүгч байрлана.

3.7.10.Тэмцээний талбайн шүүгчид нь цагаан, улаан тугтай байна. Харайлтыг тооцвол цагаан, тооцоогүй бол улаан тугийг өргөж, сул гүйсэн оролдлогын үед хоёр тугийг зөрүүлж, доош чиглэлтэй барин мэдэгдэнэ.

3.7.11.Харайлтыг тооцох:

3.7.11.1.Урьдчилсан гүйлтээс үсрэлтийн банданд шилжин түлхэлт авч харайлтыг гүйцэтгэн давхарлан өрсөн малгайн загварыг унагалгүйгээр давах явцад малгайн дүрс тамирчны биеийг босоо тэнхлэгээр хоёр хуваасан шугаман доогуур дайран гарч, цааш буулт хийгээд цэх зогсож баруун гарыг шулуун дээш өргөсөн тохиолдолд харайлтыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.

3.7.11.2.Тамирчин малгайн загвар дээгүүр давах үед түүнийг шүргэсэн хэдий ч унагаагүй бол харайлтыг гүйцэтгэсэнд тооцно.

3.7.11.3.Тамирчин харайлтыг хийж, газарт буултыг гүйцэтгээд цэх зогсож баруун гарыг өргөснөөс хойш малгай унавал харайлтыг тооцно.

3.7.12.Харайлтыг хүчингүйд тооцох:

3.7.12.1.Урьдчилсан гүйлтээс харайгаагүй ч түлхэлтийн тавцан, модон моринд хүрсэн тохиолдолд харайлтыг амжилтгүй гүйцэтгэсэнд тооцно.

3.7.12.2.Малгайн дүрс дээгүүр давах үед тамирчны бие малгайн дүрстэй босоо тэнхлэгийн дагуу нэг шугаманд байгаагүй буюу баруун, зүүн тийш биеэр хазайсан, аль нэг хөлийг илүү өргөж малгайн дүрсэн дээгүүр гаргасан тохиолдолд харайлтыг хүчингүйд тооцно.

3.7.12.3.Буултыг гүйцэтгэх үед биеийн хажуугаар унах, бүтэн биеэр суулт, уналтыг хийсэн үед харайлтыг хүчингүйд тооцно.

3.7.12.4.Харайлтыг гүйцэтгэсэн боловч буултыг хийн цэх зогсож, баруун гарыг өргөхөөс өмнө малгай унасан тохиолдолд харайлтыг хүчингүйд тооцно.

3.7.12.5.Модон моринд гараар тулалгүй /хүрэлгүй/ буулт хийсэн тохиолдолд харайлтыг хүчингүйд тооцно.

3.7.13.Модон моринд малгай тавьж харайх төрлийг дүгнэх, байр эзлүүлэх:

3.7.13.1.Хувийн дүнг хэн олон малгай дээгүүр харайсан амжилтаар нь жагсааж, байр эзлүүлэн дүгнэнэ.

3.7.13.2.Хувийн дүнгээр харайлтын оноо тэнцсэн тохиолдолд доорх нөхцөлийг харгалзан байр эзлүүлнэ. Үүнд:

3.7.13.2.1.Харайсан малгайн тоо тэнцвэл эхний захиалгын тоогоор;

3.7.13.2.2.Тэнцвэл хэд дэх оролтоор харайсан байдлаар;

3.7.13.2.3.Оролт тэнцвэл сугалааны дарааллаар;

3.7.13.3.Тэмцээнд нэг ч оролдлого гүйцэтгээгүй тамирчин, багийн дутуу гишүүнийг хамгийн сүүлийн байр эзэлсэнд тооцон дүгнэнэ.

3.7.13.4.Модон моринд малгай тавьж харайх төрлийн багийн дүнг оролцсон хоёр тамирчны эзэлсэн байруудын нийлбэрээр гаргана.

3.7.13.5.Багийн оноо тэнцвэл тамирчдын амжилтын харгалзан дүгнэнэ.

### **3.8. Сонс сэргэлтийн төрөл:**

3.8.1. Сонс эргэх төрөлд тамирчин нь дүүжингийн хөндлөвчинд бэхлэгдсэн 2 гарын тулалт, биеийн савалтыг ашиглан хөндлөвчийг тэнхлэгийн дагуу 360 градус тойрог үүсгэн эргэх хөдөлгөөнийг үргэлжлүүлэн хийх дасгалыг гүйцэтгэнэ.

3.8.2. Эргэлт гүйцэтгэх үед тамирчинд тохой, өвдөгийг нугалахгүй, хөл нийлүүлсэн байх шаардлага тавигдана.

3.8.3. Тэмцээний шүүгч тамирчны гарын бэхлэгээг шалгаж, шаардлага хангасан үед эргэлтийг эхлүүлэх зөвшөөрөл өгнө.

3.8.4. Тэмцээнд оролцогч тамирчин 1 удаа сонс эргэх оролдлого хийнэ.

3.8.5. Эргэж эхэлсэн чиглэлийг 1 удаа эсрэг чиглэлд өөрчлөхийг зөвшөөрнө.

3.8.6. Дүүжингийн тулгуур хөлийг гараа буюу 0 цэгт тооцно.

3.8.7. Эргэлт гүйцэтгэж байх үед өвдөг, тохой, биеийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү нугалсан, хөл салгасан тохиолдол бүрийг алдаанд тооцно.

3.8.7.1. Алдаа гаргасан тамирчинд 3 удаа анхааруулга өгнө.

3.8.7.2. Анхааруулга дуусмагц үргэлжлүүлэн анхааруулах шар торгууль, мэдэгдэх ногоон торгууль, дасгалыг дуусгавар болгох улаан торгуулийг дараалалын дагуу өгнө.

3.8.7.3. Улаан торгууль авч дасгалыг дуусгасан тамирчны сонс эргэсэн амжилтаас торгуулийн 3 оноог хасаж дүгнэнэ.

3.8.7.4. Шүүгч нь цагаан туг өргөж эхлүүлэх, улаан туг өргөж дуусгах дохиог өгнө. Анхааруулга ба торгуулийг тамирчинд мэдэгдэнэ.

#### **3.8.8. Эргэлтийг тооцох:**

3.8.8.1. Тамирчин дурын байрлалаас савалт хийн эргэлтийг эхлүүлж, нэг чиглэлд 360 градус тойрог үүсгэн эргэж 0 цэгийг дайран өнгөрмөгц тоолж эхлэнэ. Цаашид 0 цэгийг дайран өнгөрсөн эргэлт бүрийг тоонд тооцно.

3.8.8.2. Эргэлтийг гүйцэтгэж байх үед дүүжингийн хөндлөвчийн дээр, доор босоо тэнхлэгийн дагуу дайран өнгөрөхөөс бусад үед биеийг 30 градус хүртэл нугалахыг зөвшөөрнө.

3.8.8.3. Эргэлтийн тоо 200 түүнээс дээш болсон тохиолдолд савалт хийх зорилгоор өвдөгийг 30 градус хүртэл нугалахыг зөвшөөрнө.

3.8.8.4. Эргэлтийн тоо 400 түүнээс дээш болсон тохиолдолд савалт хийх зорилгоор өвдөгийг 45 градус хүртэл нугалахыг зөвшөөрнө.

#### **3.8.9. Эргэлтийг зогсоох:**

3.8.9.1. Улаан торгууль авсан тамирчны эргэлтийг зогсоож түүнээс хойш эргэсэн эргэлтийг хүчингүйд тооцно.

3.8.9.2. Эргэлт хооронд илүү савалт хийвэл эргэлтийг зогсооно.

3.8.9.3. Эргэж эхэлсэн чиглэлийг нэгээс дээш удаа эсрэг чиглэлд өөрчилсөн тохиолдолд эргэлтийг зогсооно.

3.8.9.4. Тамирчны бэхлэгээ сулрах, мултрах, тамирчин гэмтэл, бэртэл авсан, шүүгч аюултай түвшинд хүрсэн гэж үзвэл эргэлтийг зогсооно.

3.8.9.5. Багийн ахлагч, дасгалжуулагч дуусгах хүсэлт гаргасан бол эргэлтийг зогсооно.

#### **3.8.10. Сонс эргэлтийн төрлийг дүгнэх, байр эзлүүлэх:**

3.8.10.1. Хувийн дүнг тамирчдын сонс эргэсэн тоогоор дүгнэж, их онооны системээр байр эзлүүлнэ.

3.8.10.2.Багийн дүнг оролцсон 2 тамирчны сонс эргэсэн тооны нийлбэрээр дүгнэж, их онооны системээр байр эзлүүлнэ.

### 3.9. **Олон төрөлт:**

3.9.1. Олон төрөлтийн тэмцээнд тамирчид дүүжин, суга савлуур, модон моринд харайх, чөлөөт хөдөлгөөний дасгалуудыг гүйцэтгэнэ.

#### 3.9.2. Модон моринд гүйцэтгэх дасгал:

3.9.2.1. Модон моринд харайх төрөлд тамирчин хөл салгаж харайх, хөл чихэж харайх харайлтыг тус бүр нэг удаа гүйцэтгэнэ.

3.9.2.2. Модон моринд харайх дасгалын нийлбэр үнэлгээ 10 балл.

3.9.2.3. Тамирчин урьдчилсан гүйлтээс түлхэлтийн тавцан, модон моринд хүрэлгүйгээр сул гүйснийг оролдлогод тооцохгүй. Дахин гүйцэтгэнэ.

#### 3.9.2.4. Модон моринд хөл салгаж харайх дасгал:

3.9.2.4.1. Гүйлтээс үсрэлтийн тавцанд шилжиж түлхэлтээр үсэрч хоёр хөлийг нийлүүлэн нисэлт хийж, модон морины цаад үзүүр дээр гараар тулмагц хөлийг шулуунаар салгаж, 2 гарыг хажуу дээш алдлан хотойлт хийн бууна.

3.9.2.4.2. Модон моринд хөл салгаж харайх төрлийн үнэлгээ 10 балл.

3.9.2.4.3. Гүйлтээс түлхэлт хийхдээ эргэлзэж хөдөлгөөнөө сааруулах, түлхэлт хиймэгцээ хөлийг шууд салгах, морин дээр гарыг цувруулан тавих, өвдөг тохой нугалах, буултын алдаа гаргах зэргийг үнэлгээ бууруулах алдаанд тооцно.

#### 3.9.2.5. Модон моринд хөл чихэж харайх дасгал:

3.9.2.5.1. Гүйлтээс түлхэлтийн тавцанд шилжиж түлхэлт аван үсэрч, модон морин дээр гараар тулмагц хөлөө нийлүүлэн нугалаад 2 гарын хоорондуур чихэж гарган, 2 гарыг хажуу дээш алдлан хотойлт хийн бууна.

3.9.2.5.2. Модон моринд хөл чихэж харайх төрлийн үнэлгээ 10 балл.

3.9.2.5.3. Гүйлтээс түлхэлт хийхдээ эргэлзэж хөдөлгөөнөө сааруулах, хөл чихэх үед хөлийг модон морь болон өөрийн биенд хүргэх, модон морины дунд гарыг цувруулан тавих, буултыг буруу гүйцэтгэх зэргийг үнэлгээ бууруулах алдаанд тооцно.

#### 3.9.3. Дүүжинд заавал гүйцэтгэх дасгал:

№	Гүйцэтгэх дасгал, хөдөлгөөн	Авах балл
1	Хэрэглэлд орох,дүүжлэлт,өнцөг барилт, хөлийг буулгах	0.5
2	Татаж давах	0.5
3	Савалтанд орох, савалтаас цохиж гарах	2.0
4	Урагш эргэлт	1.0
5	Гэдэргээ эргэлт	1.0
6	Урагш савалтанд орж, хөл салганалхаж дарж гарах /хөл шулуун/	2.0
7	Уг байрлалаасаа урагш эргэлт/аль нэг гарыг эргүүлж барих/	1.0
8	Гар дээр 180 градус эргэн, түр зогсолт хийх /2 сек/	0.5
9	180 градус эргэн,хөндлөвч дээгүүр тэгнэж буух	1.5
Бүгд		10 балл

**3.9.4. Суга савлуурт заавал гүйцэтгэх дасгал:**

№	Гүйцэтгэх дасгал, хөдөлгөөн	Авах балл
1	Үсрэлтээс өнцөг барьж дүүжлэгдэн цохиж гарах	1.5
2	Савалтаас мөрөн дээр түр зогсолт, өнхрөлтөөс сугадан савалтанд орж хойш савалтаас дарж гарах	1.0
3	Урагш савалтаас өнцөг барилт /3сек/	0.5
4	Хойш уналтнаар дүүжлэгдэн савалтанд ормогц биеийг нумлан түлхэж суган дээр шилжих	2.0
5	Урагш савалтаас цохиж гарах	1.5
6	Хойш савалтаас мөрөн дээр зогсолт/1 сек/, хөлийн савалтаар гар дээр зогсолт	2.0
7	Гар дээр зогсолтоос /гар шилжүүлж/ 180 градус эргэж буух	1.5
Бүгд		10 балл

**3.9.5. Чөлөөт хөдөлгөөний заавал гүйцэтгэх дасгал:**

№	Гүйцэтгэх дасгал, хөдөлгөөн	Авах балл
1	Гүйлтээс нисэлттэй урагш өнхрөлт	1.0
2	Дахин урагш өнхрөөд 3 цэгийн тулалттай эргэлт	1.5
3	Баруун хөлийн савалттай үсрэлтээр 180 градус эргэж, зүүн хөл дээр газардаж баруун хөлийг татаж зэрэгцүүлэн тавих	0.5
4	Гүйлтээс урагш тулалттай эргэлт /2 хөл дээр бууна/, дээш үсрэн 360 градус эргэх	1.5
5	“Хараацай зогсолт” /3сек/, үндсэн зогсолтонд шилжих	0.5
6	Баруун /зүүн/ хөлийг арагш дээш өргөн, урагш унан тулж хэвтээд шлагат суух	1.0
7	Баруун /зүүн/ хөлийг хойш татан урагш тулж хэвтэн хүчээр гар дээр зогсох /2сек/, урагш өнхрөлт	1.5
8	Урагш давших алхаа хийж 180 градус эргэх	0.5
9	Эрэгтэй: Гүйлтээс хажуу тийш тулалттай эргэлт /рондат/, хойш тулалттай эргэлт /фляк/, хотойлттой үсрэлт, буулт	2.0
	Эмэгтэй: Гүйлтээс хажуу тийш тулалттай эргэлт /рондат/, үсрэлтээр 180 градус эргэлт, хотойлттой үсрэлт, буулт	
Бүгд		10 балл

**3.9.6. Олон төрөлтийн тэмцээнийг дүгнэх, байр эзлүүлэх:**

3.9.6.1. Модон моринд харайх төрлийн дүнг хоёр харайлтын баллын нийлбэрийн дундажаар гаргаж, их онооны системээр байр эзлүүлнэ. Оноо тэнцвэл хөл салгаж харайх дасгалын баллын илүүгээр дүгнэх ба балл тэнцвэл сугалаагаар байр эзлүүлнэ.

3.9.6.2. Дүүжин, суга савлуур, чөлөөт хөдөлгөөн төрөл тус бүрийн хувийн дүнг тамирчдын авсан баллыг жагсааж, их онооны системээр дүгнэх ба оноо тэнцвэл өндөр баллын дасгалыг гүйцэтгэхэд авсан баллын илүүгээр дүгнэж байр эзлүүлнэ.

3.9.6.3. Олон төрөлтийн тэмцээний хувийн нийлбэр дүнг гаргахдаа тамирчны дөрвөн төрөлд авсан баллыг нэмж, их онооны системээр байр эзлүүлж дүгнэнэ.

3.9.6.4. Оноо тэнцсэн тохиолдолд тухайн тамирчдын дасгалын гүйцэтгэлээр дүгнэх ба суга савлуур, дүүжин, чөлөөт хөдөлгөөн, модон морь гэсэн дарааллаар үзүүлсэн амжилтуудыг харгалзан байр эзлүүлнэ.

3.9.6.5. Олон төрөлтийн тэмцээний багийн нийлбэр дүнг тухайн багаас оролцсон тамирчдын төрөл тус бүрт авсан баллын нийлбэрээр дүгнэж, их онооны системээр байр эзлүүлэх ба оноо тэнцвэл амжилтын илүүгээр байр эзлүүлнэ.

### **3.10. Цэрэгжлийн гимнастикийн тэмцээний ерөнхий дүн гаргах:**

3.10.1.Цэрэгжлийн гимнастикийн тэмцээний хувийн дүнг сонс эргэх, модон моринд малгай тавьж харайх, олон төрөлт тус бүрт гаргаж байр эзлүүлнэ.

3.10.2.Багийн дүнг сонс, модон моринд малгай тавьж харайх, олон төрөлт гэсэн гурван төрөл тус бүрт багийн эзэлсэн байрын нийлбэр дүн буюу бага оноогоор дүгнэнэ.

3.10.3.Оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж байр эзлүүлнэ.

## **Дөрөвдүгээр бүлэг.**

### **ЦЭРЭГЖЛИЙН БУУДЛАГА**

4.1. Цэрэгжлийн буудлагын тэмцээн нь доорх төрлүүдээр явагдана. Үүнд:

4.1.1. Гар бууны тогтоол буудлага: Эрэгтэй, эмэгтэй.

4.1.2. Гар бууны хурдан буудлага: Эрэгтэй, эмэгтэй.

4.1.3. Автоматын буудлага: Эрэгтэй, эмэгтэй.

4.2. Цэрэгжлийн буудлагын тэмцээний бүх үйл ажиллагаа нь ахлах шүүгчийн нэгдсэн дохио, командаар явагдах ба Зэвсэгт хүчний “Буудлагын заавар”, зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөнө.

4.3. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь тамирчдад тэмцээнд оролцох болон тэмцээний бэлтгэл буудлага хийх тутамд зэвсэглэл, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг нэг бүрчлэн танилцуулж, мөрдүүлэн гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.

4.4. Тамирчдыг буудлага гүйцэтгэсний дараа шүүгчийн зөвшөөрөлгүйгээр байнд 2 м-ээс дотогш зайнд ойртох, өөрийнхөөс бусад бай руу очих, байнд хүрэхийг зөвшөөрөхгүй. Зөрчсөн тохиолдолд тухайн тамирчны буудсан онооны хамгийн бага оноог хасаж дүгнэнэ.

4.5. Цэрэгжлийн буудлагын тэмцээнд доорх зүйлийг хориглоно. Үүнд:

4.5.1. Шатаагч, гэрэлтэгч, зөвшөөрөгдөөгүй сум, галт хэрэглэлийг тэмцээнд ашиглах;

4.5.2. Тэмцээний шүүгчийн олгосон сумыг шүүгчийн зөвшөөрөлгүй өөрийн сумаар солих болон нэмэлт сумаар буудлага хийх;

4.5.3. Тэмцээнд ашиглах буудлагын зэвсэгт дуран, хараа, хэрэгсэл, оосор, зөөлөвч, хацравч, бусад зүйлсийг нэмэлтээр суурилуулах;

4.5.4. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах аюулгүйн арга хэмжээг зөрчих;

#### **4.6. Багийн бүрэлдэхүүн:**

4.6.1. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцохыг зөвшөөрнө.

4.6.2. Тэмцээнд оролцох нэг баг нь төрөл тус бүрт эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин, нийт 6 хүртэл тамирчны бүрэлдэхүүнтэй байна.

4.6.3. Автоматын төрөлд оролцсон тамирчин гар бууны төрөлд, гар бууны төрөлд оролцсон тамирчин автоматын төрөлд оролцохыг зөвшөөрөхгүй.

4.6.4. Гар бууны тогтоол буудлагын төрөлд өрсөлдсөн тамирчин гар бууны хурдан буудлагын төрөлд оролцож болно.

#### **4.7. Хувцаслалт:**

4.7.1. Цэрэгжлийн буудлагын тэмцээнд оролцох тамирчин нь дүрэмт хувцас өмсөх зааварт заасны дагуу хээрийн хувцастай байна.

4.7.2. Гар бууны төрөлд оролцох тамирчид ташаанд зүүх зориулалттай гар бууны гэртэй /кабур/, нөөц 1 магазинтай, хурдан буудлагын тамирчид нөөц 2 магазинтай байна.

4.7.3. Тэмцээнд оролцож байгаа тамирчид буудлага хийх үедээ 25x15 см-ээс багагүй хэмжээтэй хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг тамирчны нуруунд байрлуулна.

4.7.4. Тамирчин нь шүүгчийн зөвшөөрснөөр гар хамгаалах зориулалтаар гарын хурууны 1-р үе ил гарсан бээлий, өнгөгүй нүдний шилтэй байж болно.

4.7.5. Буудлагын талбайн шүүгчийн дохио, команд сонсогдох нөхцөлийг хангасан чихэвч хэрэглэхийг зөвшөөрнө.

#### **4.8. Буудлагын бай, байны аравч:**

4.8.1. Цэрэгжлийн буудлагын тэмцээнд 9 мм-ийн ПМ загварын гар буу, 7,62 мм-ийн АК, АКМ загварын автомат бууг ашиглана.

4.8.2. Тэмцээний үед өөрт болон бусдад саад болохооргүй нөхцөлийг хангасан, ерөнхий шүүгчээс зөвшөөрөгдсөн дуран ашиглахыг зөвшөөрнө.

4.8.3. Тэмцээнд ашиглагдах бай нь 50x50 см-ээс багагүй хэмжээтэй, 0,8 см-ээс зузаангүй модон /панер, аргелет/ материалаар хийгдсэн аравчтай байна.

4.8.4. Автоматын буудлагын төрлийн байны аравч нь 2 хөлтэй байна. Байны аравчны хөлийг газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийж, байны ар талд, аравчны баруун, зүүн эрмэгт бэхэлсэн байна.

4.8.5. Буудлагын байг сууринаас /газраас/ дээш 20-30 см өндөрт байрлуулна.

4.8.6. Тэмцээнд оролцож байгаа тамирчин буудлагын байны зүүн дээд өнцөгт сугалааны дугаарыг тод харагдахаар тэмдэглэсэн байна.

4.8.7. Онооны шүүгч буудлагын байны баруун дээд өнцөгт тамирчны амжилтыг тодорхой тэмдэглэнэ.

4.8.8. Цэрэгжлийн буудлагын төрлүүдэд 50x50 см хэмжээтэй, 10 хүртэл онооны үнэлгээтэй, спорт цаасан байнуудыг ашиглана.

Гар бууны тогтоол буудлагын спорт бай №4	Гар бууны хурдан буудлагын спорт бай №1	Автоматын буудлагын бай №4а
		

#### 4.9. **Гар бууны тогтоол буудлагын төрөл:**

4.9.1. Тамирчин 3+10 сумаар, 25 метрт байрлах спорт бай №4-т босоо байрлалаас буудах дасгалыг боловсруулна.

4.9.2. Буудлагыг гар дээрээс гүйцэтгэнэ. Хоёр гар ашиглахыг зөвшөөрнө. Тулгуур ашиглахыг зөвшөөрөхгүй.

4.9.3. Буудах хугацаа 10 минут хүртэл.

#### 4.10. **Гар бууны хурдан буудлагын төрөл:**

4.10.1. Тамирчин 25 метрт байрлах спорт бай №1-т 15 сумыг 3 үед босоо байрлалаас хурдан буудах дасгалыг боловсруулна. Үе тус бүрт 5 сум буудна. Буудлагыг 1 байнд гүйцэтгэнэ.

4.10.2. Буудах хугацаа 1-р үед 10 секунд, 2-р үед 8 секунд, 3-р үед 6 секунд байна.

4.10.3. Үе тус бүрийн хооронд 10 секундын хугацаатай түр зогсолт хийх ба энэ хугацаанд дараагийн буудлагад бэлтгэнэ.

4.10.4. Буудлагыг гар дээрээс гүйцэтгэнэ. Хоёр гар ашиглахыг зөвшөөрнө. Тулгуур ашиглахыг зөвшөөрөхгүй.

4.10.5. Буудлагын үе бүрийг “ЭХЭЛ” командаар эхлүүлж, “ЗОГС” командаар зогсооно. Хугацаа дууссанаас хойш буудаагүй сумыг хураан авна.

#### 4.11. **Автоматын буудлагын төрөл:**

4.11.1. Тамирчин 3+10 сумаар, 100 метрт байрлах бай №4а-д хэвтээ байрлалаас буудах дасгалыг боловсруулна.

4.11.2. Буудлагыг тулгуур ашиглахгүй, хоёр гар дээрээс гүйцэтгэнэ. Оосор ашиглахыг зөвшөөрнө.

4.11.3. Буудах хугацаа 10 минут хүртэл.

#### 4.12. **Дүгнэх:**

4.12.1. Буудлагын аюулгүй ажиллагааны заавар зөрчсөн тамирчныг тэмцээнээс шууд хасаж, буудлагыг зогсоон үлдсэн сумыг хураана.

4.12.2. Буудлагын амжилтыг байнд туссан онооны нийлбэрээр дүгнэнэ.

4.12.3. Сум онооны зураасыг сэтэлсэн тохиолдолд их оноонд тооцно.

4.12.4. Байнд хөндлөн /өөр биетээс ойсон/ орсон, сум туссанаас өөр байдлаар үүссэн нүхийг оноонд тооцохгүй.

4.12.5. Байнд илүү сум орсон тохиолдолд тухайн тамирчны авсан хамгийн өндөр онооноос эхлэн илүү орсон сумны тоогоор хасаж тооцно.

4.12.6. Буудлага гүйцэтгэж байх үед бай унасан тохиолдолд буудлагыг зогсоож, үлдсэн сумыг хураана. Буудлагыг цааш үргэлжлүүлэх буюу дахин гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

4.12.7. Хурдан буудлагын төрлөөс бусад төрөлд сум баарсан тохиолдолд талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр дахин сумыг олгож, буудлагыг үргэлжлүүлнэ. Хурдан буудлагын төрөлд сум баарвал сумыг нөхөж олгохгүй.

4.12.8. Хурдан буудлагаас бусад төрөлд буу гацсан тохиолдолд шүүгчийн зөвшөөрлөөр бууны гацааг гаргаад шүүгчээс зөвшөөрөл авсны дараа буудлагыг үргэлжлүүлж болох ба энэ нь буудах хугацаанд нөлөөлөхгүй.

4.12.9. Хурдан буудлагын төрөлд буу гацсан тохиолдолд тухайн үеийн буудлагыг зогсоох ба сумыг нөхөж олгохгүй. Тамирчин түр зогсолтын хугацаанд буудлагад бэлэн болсон бол тэмцээнийг цааш үргэлжлүүлнэ. “ЭХЭЛ” команд өгсөнөөс хойш цаг зогсохгүй.

4.12.10. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно.

#### **4.13. Цэрэгжлийн буудлагын тэмцээний ерөнхий дүн гаргах:**

4.13.1. Цэрэгжлийн буудлагын тэмцээний төрөл тус бүрийн хувийн дүнг тамирчдын авсан буудлагын нийлбэр оноог жагсааж их оноогоор байр эзлүүлнэ.

4.13.2. Хувийн оноо тэнцвэл доорх дарааллын дагуу дүгнэнэ. Үүнд:

4.13.2.1. Тамирчдын оносон их онооны амжилтын илүүгээр;

4.13.2.2. Сорилын буудлага гүйцэтгэсэн онооны илүүгээр;

4.13.2.3. Сорилын буудлага гүйцэтгэсэн их онооны амжилтын илүүгээр;

4.13.2.4. Сугалааны дарааллаар;

4.13.3. Цэрэгжлийн буудлагын тэмцээний багийн нэгдсэн дүнг тухайн багаас тэмцээнд оролцсон тамирчдын буудлагын онооны нийлбэр буюу их онооны системээр дүгнэж, байр эзлүүлнэ.

4.13.4. Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Тавдугаар бүлэг.**

### **ЦЭРГИЙН ГУРВАН ТӨРӨЛТ**

5.1. Цэргийн гурван төрөлтийн тэмцээн нь автоматын буудлага, гранат мэргэн шидэлт, 3000 метрийн гүйлт гэсэн төрлүүдээр явагдана.

5.2. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцохыг зөвшөөрнө.

5.3. Тэмцээнд оролцох нэг баг нь 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.4. Тэмцээний мэдүүлэгт багийн гишүүдийн дасгал гүйцэтгэх дараалал /этап/-ыг тусгана. Тэмцээн эхэлсэнээс хойш дарааллыг солихыг зөвшөөрөхгүй.

5.5. Цэргийн гурван төрөлтийн тэмцээнд доорх зүйлийг хориглоно. Үүнд:

5.5.1. Шүүгчийн дохио, командгүйгээр үйлдэл хийх;

5.5.2. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээг зөрчих;

5.5.3. Шатаагч, гэрэлтэгч сум болон зөвшөөрөгдөөгүй сум, галт хэрэгслийг тэмцээнд ашиглах;

5.5.4. Тэмцээний шүүгчийн олгосон сумыг шүүгчийн зөвшөөрөлгүй өөрийн сумаар солих болон нэмэлт сумаар буудлага хийх;

5.5.5. Тэмцээнд ашиглах буудлагын зэвсэгт дуран, хараа, хэрэгсэл, зөөлөвч, хацравч, бусад зүйлсийг нэмэлтээр суурилуулах;

#### **5.6. Хувцаслалт:**

5.6.1. Цэргийн гурван төрөлтийн тэмцээнд оролцох тамирчин нь бэлтгэлийн хувцастай, дүрэмт хувцас өмсөх зааварт заасны дагуу хээрийн малгай, цэрэг бүс, автомат буу, подсумкатай, буундаа 1, подсумканд 2 магазинтай, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг цээж, нуруунд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

5.6.2. Тэмцээний 3000 метрийн гүйлтийн төрөлд оролцох үед нэмэлтээр газ эсэргүүцэгчтэй байх ба буундаа давхар оосор, бусад хэрэгсэл хийхийг зөвшөөрнө.

5.6.3. Буудлага, гранат шидэх төрөлд нэмэлтээр оосор, бусад хэрэгсэл ашиглахыг хориглоно.

5.6.4. Тамирчин нь шүүгчийн зөвшөөрснөөр гарын хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлий, өнгөгүй нүдний шилтэй байж болно.

5.6.5. Талбайн шүүгчийн дохио, команд сонсогдох нөхцөлийг хангасан чихэвч хэрэглэхийг зөвшөөрнө.

#### **5.7. Зэвсэг, хэрэглэл:**

5.7.1. Тэмцээнд 7,62 мм-ийн АК, АКМ, АКМС загварын автомат буу, 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатын загвар, МО-4, ПМГ-2 загварын шүүгч газ эсэргүүцэгчийг ашиглана.

5.7.2. Цэргийн гурван төрөлтийн тэмцээний буудлагын төрөлд толгойн дүрс бүхий 100х50 см хэмжээтэй бай №7-г ашиглана.

5.7.3. Буудлагын бай нь 2 хөлтэй, хөлийг газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийж, байны ар талд, аравчны баруун, зүүн эрмэгт бэхэлнэ.

5.7.4. Буудлагын байг сууринаас /газраас/ дээш 20-30 см өндөрт байрлуулна.

5.7.5. Тэмцээнд оролцож байгаа тамирчин буудлагын байны зүүн дээд өнцөгт сугалааны дугаарыг тод харагдахаар тэмдэглэсэн байна.

5.7.6. Онооны шүүгч буудлагын байны баруун дээд өнцөгт тамирчны амжилтыг тодорхой тэмдэглэнэ.

#### **5.8. Автоматын буудлагын төрөл:**

5.8.1. Тамирчин 200 м зайнд байгаа буудлагын байнд хэвтээ, суугаа, босоо байрлалаас, байрлал тус бүрт 10 сум хугацаатайгаар буудах дасгалыг гүйцэтгэнэ.

5.8.2. Буудах хугацаа хэвтээ байрлалаас 15 секунд, суугаа байрлалаас 20 секунд, босоо байрлалаас 25 секунд байна.

5.8.3. Байны оноог тэмдэглэж, буудлагад бэлэн болсны дараа шүүгчийн командаар дараагийн байрлалын буудлагыг гүйцэтгэнэ.

5.8.4. Буудлагыг автоматын богино ээлжээр /2 буюу түүнээс дээш сум гаргаж/ буудна. Сүүлчийн сумыг нэгээр гаргахыг зөвшөөрнө.

5.8.5. Буудлагыг магазинаар тулж, оосор ашиглан гүйцэтгэхийг зөвшөөрнө.

5.8.6. Суугаа байрлалаас буудах үед хоёр хөлийг жийж суух, завилж суух, хоёр өвдөгөөр сөхөрч суухаас бусад ерөнхий шүүгчийн зөвшөөрсөн буудах аюулгүй байдлыг хангасан нөхцөлөөр сууж буудахыг зөвшөөрнө.

5.8.7. Буудлагыг “ЭХЭЛ” командаар эхлүүлж, “ЗОГС” командаар дуусгана. “ЭХЭЛ” команд өгсөнөөс хойш цаг зогсохгүй.

5.8.8. Цэргийн гурван төрөлтийн буудлагын төрлийн бүх үйл ажиллагаа нь талбайн ахлах шүүгчийн нэгдсэн дохио, командаар явагдах ба Зэвсэгт хүчний “Буудлагын заавар”, зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээний зааврыг чанд мөрдөнө.

5.8.9. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь тамирчдыг тэмцээнд оролцох болон тэмцээний бэлтгэл буудлага хийх тутамд зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг нэг бүрчлэн танилцуулж, мөрдүүлэн гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.

5.8.10. Буудлагын төрлийг дүгнэх:

5.8.10.1. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний заавар зөрчсөн тамирчныг тэмцээнээс шууд хасна.

5.8.10.2. Тамирчин тэмцээний сахилга зөрчих, шүүгчийн шаардлагыг эс биелүүлэх, шүүгчтэй маргалдах, ёс бус үг хэрэглэсэн тохиолдолд эхний удаа шар карт, хоёр дах удаад зөрчил давтагдсан тохиолдолд улаан карт өгч тамирчныг тэмцээнээс хасна.

5.8.10.3. Талбайн шүүгчийн “ЗОГС” команд өгснөөс хойш буудлага явагдсан тохиолдолд тухайн тамирчинд 1 онооны торгууль өгнө.

5.8.10.4. Буудлагын явцад сумыг нэгээр гаргаж буудсан тохиолдол бүрт тухайн тамирчныг 1 оноогоор торгоно.

5.8.10.5. Буудлагын амжилтыг байнд орсон нийт сумны тоогоор дүгнэнэ.

5.8.10.6. Байнд туссан сум байны захын зураас сэтэлсэнийг оноонд тооцно.

5.8.10.7. Байнд хөндлөн /өөр биетээс ойсон/ орсон, сум туссанаас өөр байдлаар үүссэн нүхийг оноонд тооцохгүй.

5.8.10.8. Буудлага гүйцэтгэж байх үед бай унасан тохиолдолд буудлагыг цааш үргэлжлүүлэх буюу дахин гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

5.8.10.9. Сум баарсан тохиолдолд тамирчин бууны замгийг татан дахин сумалж буудлагыг үргэлжлүүлж болох ба сумыг нөхөж олгохгүй. Хугацаа зогсохгүй.

5.8.10.10. Буу гацсан тохиолдолд буудлагыг зогсоож, тухайн ээлжийн буудлага дууссаны дараа бууг солих буюу хэвийн байдалд оруулаад талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр дараагийн ээлжийн буудлагыг гүйцэтгэж болох ба буудлагыг нөхөж гүйцэтгүүлэхгүй.

5.8.10.11. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно.

5.8.10.12. Тамирчны хувийн амжилтыг гурван байрлалаас буудсан нийт буудлагын онооны нийлбэрийн илүүгээс торгуулийн оноог хасч дүгнэн, их оноогоор байр эзлүүлнэ.

5.8.10.13. Оноо тэнцвэл босоо, суугаа, хэвтээ байрлалаас гэсэн дарааллаар, амжилтын илүүгээр дүгнэж, тэнцвэл сугалаагаар байр эзлүүлнэ.

**5.8.11. Онооны шүүгчийн дохио:**

5.8.11.1. Буудлагын онооны шүүгч нь цагаан, улаан туг ашиглан нарийн бичиг шүүгчид харагдахуйцаар дээш өргөн, мэдэгдэнэ.

5.8.11.2. Оноо заах шүүгч нь цагаан тугийг баруун гартаа, улаан тугийг зүүн гартаа доош уншуулан барьж зогссон байдлаас онооны тоогоор мөрний харалдаа хүртэл шулуун дээш өргөж 1-2 секунд барьж буулгах байдлаар дохиж, заана.

5.8.11.3. Цагаан туг 1 оноог, улаан туг 5 оноог илэрхийлнэ.

5.8.11.4. Цагаан тугаар 4 хүртэлх оноог дохиж мэдэгдэнэ.

5.8.11.5. Тамирчны авсан 5 түүнээс дээш оноог заахдаа улаан тугийг мөрний харалдаа өргөн барьж, цагаан тугаар үргэлжлүүлэн 6-9 хүртэл оноог дохиж заана.

5.8.11.6. Тамирчин 10 оноо авбал улаан тугийг 2 удаа дохино.

**5.9. Гранат мэргэн шидэлтийн төрөл:**

5.9.1. Тамирчин сорилын 3 ширхэг, тэмцээний 15 ширхэг 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатыг 40 метрийн зайд байрлах онооны тойрогт мэргэн шидэх дасгалыг боловсруулна.

5.9.2. Гранат мэргэн шидэлтийн талбай нь 1, 3, 5, 7, 9 метрийн диаметр бүхий таван тойрогтой, тойргийн голоос шулуунаар 40 метр зайд байрлах 200х100 см-ийн хэмжээтэй гранатыг шидэх зурваснаас бүрдэнэ.

5.9.3. Гранатын талбайн үнэлгээ нь голын тойргоос эхлэн 11, 7, 4, 2, 1 гэсэн оноотой байна.

5.9.4. Сорилын гранат шидэх хугацаа 3 минут хүртэл, тэмцээний гранат шидэх хугацаа 10 минут хүртэл байна.

5.9.5. “ЭХЭЛ” командаар эхлүүлж, “ДУУСГА” командаар дуусгана.

**5.9.6. Гранат мэргэн шидэх төрлийг дүгнэх:**

5.9.6.1. “ЭХЭЛ” команд өгсөнөөс хойш цаг зогсохгүй хугацаа дуустал үргэлжлэх бөгөөд ямарч нөхцөлд цагийг сунгахгүй.

5.9.6.2. Гранатыг анхны буусан цэгээр үнэлнэ. Шидсэн гранат онооны шугаман дээр буусан тохиолдолд их оноонд тооцно.

5.9.6.3. Шидсэн гранат газар буугаагүй байхад шидэх талбайн нүүрний зурвасыг шүргэсэн, гишгэсэн, давж алхсан, тамирчны малгай газарт унасан, бууг газарт хүргэсэн, гараар газарт тулсан тохиолдол бүрт тухайн гранатаар авсан оноог хүчингүйд тооцно.

5.9.6.4. Шүүгч нь шидсэн гранатыг тооцсоныг цагаан туг /дохио/ өргөж, тооцоогүй шидэлтийг улаан туг /дохио/ өргөж илэрхийлнэ.

5.9.6.5. Тамирчин тэмцээний сахилга зөрчих, шүүгчийн шаардлагыг эс биелүүлэх, шүүгчтэй маргалдах, гранат шидэх үед ёс бус үг хэрэглэсэн тохиолдолд доорх торгуулийг өгнө. Үүнд:

- 5.9.6.5.1. Эхний удаа анхааруулах шар карт;
- 5.9.6.5.2. Хоёр дах удаад дахин шар карт өгч тухайн гранатыг шидэж авсан оноог хүчингүйд тооцох;
- 5.9.6.5.3. Гурав дах удаад зөрчил давтагдсан тохиолдолд улаан картаар торгон тухайн тамирчныг тэмцээнээс хасах;
- 5.9.6.6. Сорилын хэдэн гранат шидэхийг тухайн тамирчин шийднэ.
- 5.9.6.7. Тамирчны хувийн дүнг тэмцээний 15 гранатаар авсан онооны нийлбэрээр дүгнэж, их оноогоор байр эзлүүлнэ.
- 5.9.6.8. Хувийн оноо тэнцвэл доорх дарааллаар дүгнэнэ. Үүнд:
  - 5.9.6.8.1. Тамирчдын авсан их онооны амжилтын илүүгээр;
  - 5.9.6.8.2. Сорилд шидсэн гранатын онооны илүүгээр;
  - 5.9.6.8.3. Сорилд шидсэн гранатын их онооны амжилтын илүүгээр;
  - 5.9.6.8.4. Сугалааны дарааллаар;

#### **5.10. 3000 метрийн гүйлтийн төрөл:**

- 5.10.1.Тамирчид багаараа гараанаас гарч өгсүүр, уруу, налуу, шулуун зам оролцсон 3000 м зайд маршрутын дагуу гүйж барианд орох дасгалыг гүйцэтгэнэ.
- 5.10.2.Тамирчид бэлтгэлийн хувцас, цэрэг малгай, бүс, хувийн дугаар, газ эсэргүүцэгч, автомат буу /буундаа 1, подсумкэнд 2 магазинтай/-тай байна.
- 5.10.3.Замын маршрутын дагуу 500 метр тутамд зайн хэмжээ, дараагийн маршрутыг заасан тэмдэглэгээ хийгдсэн байна.
- 5.10.4.Багууд сугалааны дарааллаар 5 минутын зайтайгаар гараанаас гарна.
- 5.10.5.Зэвсэг, хувцас, хэрэглэлийн зөрчилтэй баг, тамирчныг тэмцээний гараанаас гаргахгүй байх, тэмцээнээс хасах үндэслэл болно. Зөрчлийн улмаас гараанаас гараагүй тохиолдолд тухайн баг, тамирчны гарааны цаг зогсохгүй үргэлжлэх бөгөөд баг, тамирчид зөрчлөө арилгасны дараа гараанаас гарна.
- 5.10.6.Гүйлтийг хүн нэг бүрийн маршрут туулсан хугацаанаас гарааны цагийг хасан эцсийн цэвэр цагийг таблицад оруулан үнэлнэ.
- 5.10.7.Маршрутын замыг товчилсон, энэ нь замын шүүгчийн протоколоор нотлогдсон тохиолдолд тухайн тамирчны гүйсэн хугацааг хүчингүйд тооцно.
- 5.10.8.Зэвсэг, бусад хэрэглэл дутуу барианд орсон тохиолдолд тухайн тамирчинд 1 минутын торгууль оногдуулна.
- 5.10.9.Эмчийн магадлагаа, ерөнхий шүүгчийн гүйхийг хориглосон шийдвэрээс бусад шалтгаанаар гүйлтийн төрөлд оролцоогүй буюу гараанаас гараагүй тамирчинд таблицы хамгийн бага онооны торгууль оногдуулна.

#### **5.11. Цэргийн гурван төрөлтийн тэмцээний ерөнхий дүн гаргах:**

- 5.11.1.Тэмцээний төрөл тус бүрийн хувийн дүнг тамирчдын үзүүлсэн амжилтаар жагсааж, их оноогоор байр эзлүүлнэ.
- 5.11.2.Хувийн нэгдсэн дүнг гаргахдаа тамирчдын амжилтыг “Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангилал”-д заасан цэргийн 3 төрөлтийн таблицыноононд шилжүүлэн авсан онооны нийлбэрээр дүгнэж, их оноогоор байр эзлүүлнэ.
- 5.11.3.Хувийн оноо тэнцсэн тохиолдолд эхлээд буудлага, дараа нь гранатын төрлийн дүнг харгалзан, амжилтын илүүгээр дүгнэж, байр эзлүүлнэ.

5.11.4.Цэргийн гурван төрөлтийн тэмцээний багийн нэгдсэн дүнг тухайн багаас тэмцээнд оролцсон нийт 8 тамирчны хувийн нэгдсэн дүнгээр авсан онооны нийлбэр буюу их онооны системээр дүгнэж, байр эзлүүлнэ.

5.11.5.Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Зургадугаар бүлэг.**

### **ТУУХАЙ ӨРГӨЛТ**

6.1. Туухай өргөлтийн тэмцээн нь эрэгтэй -60, 65, 70, 75, 80, 85 кг гэсэн 6 жин, эмэгтэй 60, 70 кг гэсэн 2 жингийн ангиллаар явагдах ба ангилал тус бүрт огцом өргөлт, түлхэлттэй өргөлтийн төрлөөр зохион байгуулагдана.

6.2. Тэмцээнд оролцох нэг баг нь жин тус бүрт 1 тамирчин, нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

6.3. Тэмцээнд жингийн ангиллын шаардлага хангасан, тухайн тэмцээнийг зохион байгуулах заавар, удирдамжаар зөвшөөрөгдсөн хүн бүр оролцож болно.

6.4. Тэмцээн нь хэдэн жингийн ангиллаар явагдах, түүнд оролцох бүрэлдэхүүнийг тухайн тэмцээнийг зохион байгуулах байгууллагаас гаргасан заавар, удирдамжаар тодорхойлж болно.

6.5. Туухай өргөлтийн тэмцээнд бариул бүхий стандарт туухайг ашиглана. Туухайны жин эрэгтэй төрөлд 24 кг, эмэгтэй төрөлд 16 кг байна.

6.6. Тэмцээнийг огцом өргөлт, түлхэлттэй өргөлт гэсэн дарааллаар зохион байгуулж явуулна. Тамирчид сугалааны дарааллаар дасгалыг гүйцэтгэнэ.

6.7. Тэмцээнд аль нэг гарын тохой, өвдөгний үе нь тэмцээний оноо тооцох нөхцөлийн шаардлагыг хангахуйцаар шулуун тэнийдэггүй, өргөх үед гар, хөлийн үеийг шулуунаар түгжих боломжгүй тамирчныг тэмцээнд оролцуулахгүй.

6.8. Өргөлт гүйцэтгэх тамирчин талбайд гарч, шүүгч, үзэгчид хагас бөхийж мэндлээд туухайнаас 1 алхамын зайтай зогсоно.

6.9. Шүүгчийн “ЭХЭЛ” командаар туухайг авч өргөлтийг гүйцэтгэж эхлэх ба өргөж дуусгалаа эсвэл шүүгчийн “ДУУСГА” команд өгөх хүртэл үргэлжлүүлнэ.

6.10.Өргөлтийг дуусаад туухайг зөөлөн буулгаж, зэрэгцүүлж байрлуулаад шүүгч, үзэгчид мэндэлснээр дасгал дуусна.

6.11.Шүүгч нь тооцоогүй өргөлтийг цагаан туг /дохио/ өргөж, өргөлтийг зогсоохыг улаан туг /дохио/ өргөж илэрхийлнэ.

#### **6.12. Торгууль өгөх, өргөлтийг зогсоох:**

6.12.1.Тамирчин тэмцээний сахилга бат зөрчих, шүүгчийн шаардлагыг эс биелүүлэх, ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд эхний удаад шар карт, хоёр дах удаад зөрчил давтагдсан тохиолдолд улаан карт өгч тэмцээнээс хасна.

6.12.2.Өргөлтийг гүйцэтгэж дуусаад буулгахдаа туухайнуудыг шидсэн тохиолдолд тухайн тамирчныг 5 оноогоор торгоно.

6.12.3.Өргөлтийн явцад техникийн алдаа гарган туухайг алдсан тохиолдолд торгууль тооцогдохгүй.

6.12.4.Өргөлт гүйцэтгэж дуусаад туухайг зэрэгцүүлж байрлуулалгүй орхиж явсан тохиолдолд тухайн тамирчныг 3 оноогоор торгоно.

6.12.5.Өргөлт гүйцэтгэж байгаа тамирчин дасгал гүйцэтгэх тавцангаас гарсан тохиолдолд өргөлтийг зогсооно.

### **6.13. Хувцаслалт:**

6.13.1.Тэмцээнд оролцох тамирчин нь өвдөг, тохой ил гарч бие барьсан, гэрэлтдэггүй спорт хувцас, хатуу ултай түрийгүй спорт гутал, хамгаалалтын бүс, хувийн дугаартай байна. Тамирчдын хувийн дугаарыг цээжин тус газарт шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

6.13.2.Зөвхөн гарын алга хамгаалах зориулалтаар бүх хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлий, боолт, шуунд хамгаалалтын боолт хийхийг зөвшөөрнө.

6.13.3.Тамирчин нь эмчилгээний зориулалттай наалт, зөвшөөрөгдсөнөөс бусад нэмэлтээр хамгаалалтын хэрэглэл, бүс, боолт хийхийг хориглоно.

6.13.4.Туухайг өргөх үед гарын алга болон биед зуурах чанарыг сайжруулж, гэмтлээс сэргийлэх зорилгоор спортын зориулалтын цагаан нунтаг буюу шохой /магnez-/г хэрэглэхийг зөвшөөрнө.

6.13.5.Туухай өргөлтийн дасгалыг гүйцэтгэх үед биед байгаа цаг, бөгж, ээмэг, зүүлт, бугуйвч, чихэвчийг авсан байна.

### **6.14. Түлхэлттэй өргөлтийн төрөл:**

6.14.1.Эрэгтэй тамирчин 2 туухайг 2 гараар цээжнээс дээш зэрэг шахаж өргөх дасгалыг боловсруулна.

6.14.2.Эмэгтэй тамирчид 1 туухайг цээжнээс дээш 1 гараар шахаж өргөх дасгалыг хугацаагүйгээр гүйцэтгэнэ.

6.14.3.Эхлэх байдал: Туухайг авч гарыг нугалан тохойг биедээ нааж, шуун дээр туухайг байрлуулан, бариулаас атгасан гарыг дотогш харуулан хооронд нь ойртуулан цээжин тус газар барьж, хөлийг өвдөгөөр шулуун байдлаар мөрний хэмжээний зайтай эгц зогсоно.

#### **6.14.4. Түлхэлттэй өргөлтийг тооцох:**

6.14.4.1.Эрэгтэй тамирчид: Хоёр туухайг цээжнээс зэрэг шахаж босоо тэнхлэгийн дагуу эгц дээш өргөөд, хоёр гарын тохойг түгжиж, өвдөг тэнийлгэн бүх биеэр шулуун болж хөдөлгөөнгүй 1-2 секунд түр зогсолт хийгээд буулгаж эхлэх байдалд орж түр зогсолт хийснээр өргөлтийг тооцно.

6.14.4.2.Эмэгтэй тамирчид: Нэг туухайг цээжнээс нэг гараар шахаж босоо тэнхлэгийн дагуу эгц дээш өргөөд, тохойг түгжиж, өвдөг тэнийлгэн бүх биеэр шулуун болж хөдөлгөөнгүй 1-2 секунд түр зогсолт хийгээд буулгаж эхлэх байдалд орж 1-2 секунд түр зогсолт хийснээр өргөлтийг тооцно.

6.14.4.3.Өргөлт гүйцэтгэх явцад сул байгаа буюу савалтын гарыг биед хүргэхийг хориглоно.

6.14.4.4.Эмэгтэй тамирчид дасгалыг гүйцэтгэх явцад туухайг доош буулгалгүй цээжин дээрээс нэг гараас нөгөөд нэг удаа шилжүүлэхийг зөвшөөрнө.

6.14.4.5.Туухайг өргөхдөө хөлнөөс түлхэлт авах, хагас сууж өргөхийг зөвшөөрөх бөгөөд энэ үед өргөсөн гарын тохойг түгжиж, өвдөг тэнийлгэн бүтэн

улаар гишгэж, бүх биеэр шулуун болж, түр зогсолтоос буулгаж эхлэх байдалд орсноор өргөлтийг тооцно.

**6.14.5. Түлхэлттэй өргөлтийг зогсоох, хүчингүйд тооцох:**

6.14.5.1.Өргөлтийг эхэлснээс хойш аль нэг туухайг цээжнээс доош буулгах, алдаж унагасан тохиолдолд дасгалыг шууд зогсооно.

6.14.5.2.Мөр болон гарын хоёр толгойт булчин дээр туухайг ёроолоор нь тавьж өргөлтийг гүйцэтгэсэн тохиолдолд өргөлтийг зогсооно.

6.14.5.3.Тамирчин хүчингүйд тооцсон өргөлтийг 3-аас дээш удаа үргэлжлүүлэн гүйцэтгэвэл шүүгчийн шийдвэрээр өргөлтийг зогсооно.

6.14.5.4.Доорх тохиолдолд өргөлтийг хүчингүйд тооцно. Үүнд:

6.14.5.4.1.Босоо тэнхлэгийн дагуу эгц дээш болоогүй өргөлтийг;

6.14.5.4.2.Өргөсөн үед тохой, өвдөгний үеийг түгжээгүй өргөлтийг;

6.14.5.4.3.Туухайг зэрэг өргөөгүй буюу цувруулан өргөсөн өргөлтийг;

6.14.5.4.4.Өргөсний дараа түр зогсолтыг хийлгүй буулгасан өргөлтийг;

6.14.5.4.5.Өргөөд хөдөлгөөнгүй зогсолгүй буулгасан өргөлтийг;

6.14.5.4.6.Гүйцэд буулган эхлэх байдалд оролгүй өргөсөн өргөлтийг;

6.14.5.4.7.Эхлэх байдалд ормогц өвдөгөөр шулуун болгож, гарыг тохойгоор биед нааж, түр зогсолт хийлгүй өргөсөн өргөлтийг;

6.14.5.4.8.Эмэгтэй тамирчид дээрх шаардлагаас гадна туухайг өргөж байгаа гар болон туухайнд савалтын гараар хүрсэн, дэмжлэг үзүүлсэн тохиолдолд;

**6.14.6. Түлхэлттэй өргөлтийг дүгнэх:**

6.14.6.1.Тооцсон нэг өргөлтөөр эрэгтэйд 2 оноо, эмэгтэйд 1 оноог өгнө.

6.14.6.2.Түлхэлттэй өргөлтийн хувийн амжилтыг доорх байдлаар харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ. Үүнд:

6.14.6.2.1.Тамирчны их өргөсөн онооны илүүгээр;

6.14.6.2.2.Оноо тэнцвэл аль бага жин /эхний жингээр/-тэйгээр,

6.14.6.2.3.Дахин тэнцвэл тэмцээний дараах жингийн бага жинтэйгээр;

**6.15. Огцом өргөлтийн төрөл:**

6.15.1.Огцом өргөлтийн төрөлд нэг гараар туухайг газраас авч, салгаж зогссон хөлийн завсарт биедээ хүргэлгүй, гарыг шулуунаар доош унжуулан барьсан байдлаас гарын савалтаар огцом таталт хийж, гарыг шулуунаар босоо тэнхлэгийн дагуу эгц дээш өргөн, гарын тохойг түгжиж, өвдөг тэнийлгэн бүх биеэр шулуун болж хөдөлгөөнгүй 1-2 секунд түр зогсолт хийгээд туухайг биед хүргэлгүй гарыг шулуунаар буулгамагц газарт хүргэлгүй нэг удаагийн савалтаар дараагийн өргөлтийг үргэлжлүүлэн гүйцэтгэх дасгалыг гүйцэтгэнэ.

6.15.2.Огцом өргөлтийг баруун, зүүн гар тус бүрт 1 удаа гүйцэтгэнэ. Аль гараас эхлэж өргөхийг тамирчин өөрөө сонгоно. Дасгал гүйцэтгэх явцад нэг гараас нөгөө гарт 1 удаа амралтгүйгээр шилжүүлнэ.

6.15.3.Туухайг шилжүүлэхдээ гарыг шулуунаар, бүсэлхийнээс доош байрлалд, 1-2 удаагийн савалтаар гүйцэтгэнэ.

6.15.4.Нэг гар дасгалыг гүйцэтгэж байх үед нөгөө гарыг биед хүргэхийг хориглоно. Сул байгаа гар савалтын үүрэг гүйцэтгэж болно.

**6.15.5. Огцом өргөлтийг тооцох:**

6.15.5.1.Шүүгчийн “ЭХЭЛ” командаар туухайг авч савалтаас огцом татаж, гар шулуун байдлаар босоо тэнхлэгийн дагуу эгц дээш өргөөд, тохойг

түгжиж, өвдөг тэнийлгэн, бүх биеэр шулуун болж хөдөлгөөнгүй 1-2 секунд түр зогсолт хийгээд гар шулуунаар туухайг биед хүргэлгүй буулгамагц өргөлтийг тооцох бөгөөд нэг савалтаас өргөлтийг цааш үргэлжлүүлнэ.

6.15.5.2.Огцом өргөлтийг эхлэх болон гар солих үед 1 удаа илүү савалт хийхийг зөвшөөрнө. Өргөлт үргэлжлэх явцад илүү савалт хийхийг зөвшөөрөхгүй.

**6.15.6. Огцом өргөлтийг зогсоох, хүчингүйд тооцох:**

6.15.6.1.Өргөлт үргэлжлэх явцад нэгээс илүү савалт хийсэн тохиолдолд өргөлтийг шууд зогсооно.

6.15.6.2.Туухайг газарт хүргэсэн, шүргүүлсэн, алдаж унагасан тохиолдолд өргөлтийг зогсооно.

6.15.6.3.Тамирчин хүчингүйд тооцсон өргөлтийг 3-аас дээш удаа үргэлжлүүлэн гүйцэтгэвэл шүүгчийн шийдвэрээр өргөлтийг зогсооно.

6.15.6.4.Эхний гарын өргөлтийн тоотой дараагийн гарын өргөлтийн тоо тэнцсэн тохиолдолд өргөлтийг зогсооно.

6.15.6.5.Доорх тохиолдолд өргөлтийг хүчингүйд тооцно. Үүнд:

6.15.6.5.1.Босоо тэнхлэгийн дагуу эгц дээш болоогүй өргөлтийг;

6.15.6.5.2.Өргөсөн үед тохой, өвдөгний үеийг түгжээгүй өргөлтийг;

6.15.6.5.3.Өргөсний дараа түр зогсолтыг хийлгүй буулгасан өргөлтийг;

6.15.6.5.4.Өргөөд хөдөлгөөнгүй зогсолгүй буулгасан өргөлтийг;

6.15.6.5.5.Өргөлтөөс буулгах үед гар болон туухайг биед хүргэх;

6.15.6.5.6.Өргөлтөөс биед наалдуулан буулгаад өргөсөн өргөлтийг;

6.15.6.5.7.Хоёр гарын аль нэг хэсгээр биед хүрэх, тохой, өвдөг, ташаа болон бусад хэсгээс тулалт аван дэмжлэг үзүүлж өргөсөн өргөлтийг;

6.15.6.5.8.Өргөлтөөс гарыг шулуун байдалд оруулалгүйгээр буулгаж, нугалсан байдлаа хадгалан таталт хийж өргөсөн өргөлтийг;

**6.15.7. Огцом өргөлтийг дүгнэх:**

6.15.7.1.Тооцсон нэг өргөлтөөр 1 оноог өгнө.

6.15.7.2.Хоёр гарын өргөлтийн аль бага тоогоор өргөлтийн тоог тооцно.

6.15.7.3.Тооцсон өргөлтийн тоог 2-т үржүүлэн амжилтыг үнэлнэ.

6.15.7.4.Огцом өргөлтийн хувийн амжилтыг доорх байдлаар харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ. Үүнд:

6.15.7.4.1.Тамирчны их өргөсөн амжилтын илүүгээр;

6.15.7.4.2.Оноо тэнцвэл аль бага жин /эхний жингээр/-тэйгээр,

6.15.7.4.3.Дахин тэнцвэл тэмцээний дараах жингийн бага жинтэйгээр;

**6.16. Туухай өргөлтийн тэмцээний ерөнхий дүн гаргах:**

6.16.1.Тэмцээний түлхэлттэй, огцом өргөлтийн төрлийн жин тус бүрийн хувийн дүнг тамирчдын үзүүлсэн амжилтаар жагсааж, их оноогоор байр эзлүүлнэ.

6.16.2.Хувийн нэгдсэн дүнг тамирчдын хоёр өргөлтийн нийлбэр оноогоор тооцож, их оноогоор байр эзлүүлнэ.

6.16.3.Хувийн нийлбэр оноо тэнцвэл түлхэлттэй өргөлт, огцом өргөлт гэсэн дарааллаар өргөсөн амжилтын илүүг харгалзан дүгнэж, тэнцвэл тухайн тамирчдын жинг дахин /тэмцээний дараа/ үзэж, бага жинтэйгээр байр эзлүүлнэ.

6.16.4.Туухай өргөлтийн тэмцээний багийн нэгдсэн дүнг тухайн багаас тэмцээнд оролцсон нийт тамирчдын өргөсөн онооны нийлбэрээр дүгнэж, их оноогоор байр эзлүүлнэ.

6.16.5.Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Долдугаар бүлэг.**

### **ГАРДАН ТУЛААН**

7.1. Гардан тулааны тэмцээн нь -60, 65, 70, 75, 80, 85 кг гэсэн нийт 6 жингийн ангиллаар явагдана.

7.2. Тэмцээн хасагдах системээр зохион байгуулагдана.

7.3. Тэмцээнд оролцох нэг баг жин тус бүрт 2 эрэгтэй тамирчин, нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй байна.

7.4. Тэмцээний 1 тулаан 3 мин хугацаатай 1 үеэр, татами дээр явагдана.

7.5. Тэмцээнд гар /тохой, гарын ар, хажуугийн г.м/-ын, хөл /өвдөг, өсгий г.м/-ийн бүх цохилт, өшиглөлт, барьц авч мэх хийх, гар хөлд өчих, боох мэхүүдийг хийхийг зөвшөөрнө.

7.6. Боох, шидэх, өчих мэхийг 10 секундээс илүүгүй хугацаанд гүйцэтгэнэ.

7.7. Тэмцээний шүүгчийн бүрэлдэхүүнд ерөнхий шүүгч, дэвжээний шүүгч, хажуугийн шүүгч 3 хүн, нарийн бичиг шүүгч 1 хүн ажиллана.

7.8. Тулааны цаг дуусмагц хажуугийн шүүгчид тамирчдын оноог хүснэгтэд тэмдэглэн дэвжээний шүүгчээр дамжуулан нууцаар ерөнхий шүүгчид өгнө.

7.9. Ерөнхий шүүгч дүнг нэгтгэн ялалтыг зарлана.

#### **7.10. *Тамирчин, дасгалжуулагчид тавих шаардлага:***

7.10.1.Тамирчин сайн дурын үндсэн дээр тэмцээнд оролцох ба өөрөө баталгаа гаргаж, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт тэнцэн, мэдүүлэгт тусгагдаж, тэмцээний аюулгүйн заавартай танилцаж гарын үсэг зурсан байна.

7.10.2.Тэмцээнд тавигдах шаардлагыг хангаагүй, хувцас, баримт бичгийн зөрчилтэй байх нь тамирчныг тэмцээнээс хасах үндэслэл болно.

7.10.3.Нэг тамирчинд 2 дасгалжуулагч ажиллахыг зөвшөөрөх ба албан ёсны дасгалжуулагч, тамирчны өөрийн дасгалжуулагчаас өөр хүнийг дэвжээнд гарахыг хориглоно.

7.10.4.Дасгалжуулагчид нь биеийн тамирын хувцас өмсөөгүй тохиолдолд дэвжээнд гаргахгүй. Зөрчсөн тохиолдолд тухайн багаас дэвжээнд гарсан тамирчинд дүрмийн дагуу анхааруулга, сануулгыг өгнө.

#### **7.11. *Хувцаслалт:***

7.11.1.Тамирчид нь тулаанд кимонотой, зориулалтын толгойн шлем /нүүр, чихийг хамгаалсан төмөр торон хамгаалалттай/, хуруу гарсан бээлий, эмзэг эрхтэний болон өлмий, шилбэний үргэлжилсэн хамгаалалттай, хөл нүцгэн тоглоно.

7.11.2.Бөгж, цаг, бугуйвч, зэмэг, зүүлт, чихэвчтэй тоглохыг хориглоно.

7.11.3.Тамирчин нь хувийн ариун цэврийн шаардлагыг дээд зэргээр хангасан, гар, хөлийн хумсыг сайтар авсан байна.

7.11.4.Тамирчид хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг нуруунд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

7.11.5.Бээлийний дотор талд, хөлийн үенд эмчилгээний зориулалттай наалт, зөвшөөрөгдсөн уян боолтыг нэмэлтээр ашиглахыг зөвшөөрнө.

7.11.6.Тохой, өвдөг болон бусад биеийн хэсэгт зөвшөөрөгдсөнөөс өөр нэмэлт боолт, бусад хамгаалах хэрэгслэлийг зүүж, хэрэглэхийг хориглоно.

#### **7.12. Үнэлгээ, оноо өгөх:**

7.12.1.Босоо байдлаас гарын хүчтэй цохилт, хөлийн өшиглөлтөөр өрсөлдөгч тамирчныг хэвтээ байдалд оруулах, түр сааталд /нокдаун/ оруулах болон тоолуулах бүрт 4 оноог өгнө.

7.12.2.Торгууль авсан тамирчны эсрэг тамирчинд 2 оноо өгнө.

#### **7.12.3. Гарын цохилт:**

7.12.3.1.Гараар цохиж тэнцвэр алдуулбал 3 оноо;

7.12.3.2.Толгойд цохилт орвол 2 оноо;

7.12.3.3.Цээжинд цохилт орвол 1 оноо;

#### **7.12.4. Хөлийн өшиглөлт:**

7.12.4.1.Үсрэлтээс болон үсрэлттэй эргэлтээс өшиглөлт орвол 3 оноо;

7.12.4.2.Байрнаас толгойд өшиглөлт орвол 2 оноо;

7.12.4.3.Цээжин биед өшиглөлт орвол 1 оноо;

7.12.4.4.Хөлд өшиглөлт орвол 1 оноо;

#### **7.12.5. Шидэлт болон мэх:**

7.12.5.1.Далайцтай, нисэлттэй мэх хийсэн бол 3 оноо;

7.12.5.2.Өрсөлдөгчийг дэвжээнээс хөндийрүүлж бага зэргийн нисэлттэй мэх /өмсөх, тонгорох, үүрэх г.м/ хийж унагасан бол 2 оноо;

7.12.5.3.Мэх хийж /хавсрах, суйлах, давхар хамах, этэх, хутгах г.м/ газарт унагасан бол 1 оноо;

#### **7.13. Хориглох зүйл:**

7.13.1.Дагз, шилэн хүзүү, нугасны дагуу, цавь, шагай, үений эсрэг цохих;

7.13.2.Эмзэг эрхтэнд санаатай болон санамсаргүйгээр цохих;

7.13.3.Нүд рүү хатгах, хуруунд өчих, хөлөөр дэвсэх;

7.13.4.Шлем, болон шлемны торон хамгаалалтнаас барих, зуурах;

7.13.5.Дэвжээнээс зугтан гарах, идэвхгүй зодоон хийх;

#### **7.14. Анхааруулга, сануулга, торгууль өгөх:**

7.14.1.Хориглох зүйлийг 1 удаа үйлдсэн бол анхааруулга өгнө.

7.14.2.Анхааруулга давтагдсан бол сануулга өгнө.

7.14.3.Сануулга давтагдсан бол торгууль өгнө.

7.14.4.Торгууль давтагдсан бол эсрэг тамирчинд онооны ялалтыг өгнө.

7.14.5.Тамирчдыг дэвжээнд дуудсанаас хойш 30 секунд хоцорвол анхааруулга, 1 минут хоцорвол сануулга, 1 минут 30 секундээс цааш хоцорвол эсрэг тамирчинд онооны ялалтыг өгнө.

7.14.6.Хугацааг эхний тамирчин дэвжээнд гарч ирснээс эхлэн тооцно.

#### **7.15. Цэвэр ялалтыг тооцох:**

7.15.1.Тулааны явцад тамирчин эмчийн магадлагаагаар тоглолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон бол эсрэг тамирчинд цэвэр ялалтыг өгнө.

7.15.2.Тамирчин өөрөө буюу дасгалжуулагч татгалзсан бол эсрэг тамирчинг цэвэр ялсанд тооцно.

7.15.3.Хүнд цохилтонд /нокаут/ оруулсан бол цэвэр ялалтад тооцно.

7.15.4.Өчих мэхээр эсэргүүцэх чадваргүй болговол цэвэр ялалтад тооцно.

7.15.5.Боох мэхээр эсэргүүцэх чадваргүй болговол цэвэр ялалтад тооцно.

7.15.6.Ерөнхий шүүгч илт техникийн зөрүүтэй тулааныг зогсоож, давуу тоглосон тамирчинд цэвэр ялалт өгнө.

#### **7.16. Гардан тулааны тэмцээний ерөнхий дүн гаргах:**

7.16.1.Тэмцээний жин тус бүрт ялалт байгуулсан амжилтаар байр эзлүүлнэ.

7.16.2.Цэвэр ялалт бүрт 3 оноо, онооны ялалт бүрт 2 оноо, ялагдалд 1 оноо, тулаан хийгээгүй буюу дэвжээнд гараагүй тамирчинд 0 оноо өгч дүгнэнэ.

7.16.3.Багийн нэгдсэн дүнг багаас оролцсон нийт тамирчдын цуглуулсан онооны нийлбэрийг нэгтгэж, их оноогоор дүгнэж, байр эзлүүлнэ.

7.16.4.Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Наймдугаар бүлэг.**

### **ӨВЛИЙН ХОЁР ТӨРӨЛТ**

8.1. Өвлийн хоёр төрөлтийн тэмцээн нь биатлон /ганцаарчилсан/, патруль /багийн/ гэсэн төрлүүдээр явагдана.

8.2. Тэмцээний уралдааны зам, цана, хэрэглэл нь “Гүйлтийн цанын спортын орчин болон сургалтанд тавих шаардлага” стандартын дагуу байна.

8.3. Өвлийн хоёр төрөлтөд уралдах тамирчид цанын спортын сонгомол болон тэших техникийг ашиглана.

8.4. Өвлийн хоёр төрөлтийн тэмцээнд доорх зүйлийг хориглоно. Үүнд:

8.4.1. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах аюулгүйн арга хэмжээг зөрчих;

8.4.2. Шатаагч, гэрэлтэгч сум, галт хэрэгслийг тэмцээнд ашиглах;

8.4.3. Малгай, бээлийгүй тэмцээнд оролцох, тэдгээрийг ашиглахгүй байх;

8.4.4. Тэмцээнд ашиглах буудлагын зэвсэгт дуран, хараа, хэрэгсэл, зөөлөвч, хацравч, бусад зүйлсийг нэмэлтээр суурилуулах;

#### **8.5. Багийн бүрэлдэхүүн:**

8.5.1. Тэмцээнд оролцох нэг баг нь биатлоны төрөлд 2 тамирчин, патрулийн төрөлд 4 тамирчин, нийт 6 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.

8.5.2. Биатлоны төрөлд оролцсон тамирчин патруль төрөлд оролцохыг зөвшөөрнө.

8.5.3. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцоно.

8.5.4. Патрулийн төрлийн багийн ахлагч офицер байна.

#### **8.6. Зэвсэг, хэрэглэл:**

8.6.1. Биатлоны тамирчид автомат буу, подсумкатай, буунд 1, подсумканд 2 магазинтай байна.

8.6.2. Патрулийн төрлийн багийн ахлагч гар буу, ташаанд зүүх зориулалттай бууны гэр, буунд 1, нөөц 1 магазинтай, багийн гишүүд автомат буу, подсумкатай, буунд 1, подсумканд 2 магазинтай байна.

8.6.3. Тэмцээнд 9 мм-ийн ПМ загварын гар буу, 7,62 мм-ийн АК, АКМ, АКМС загварын автомат бууг ашиглана.

8.6.4. Тамирчид шаардлага хангасан, өөрийн цана, таягийг хэрэглэнэ.

8.6.5. Тэмцээний төрлүүдэд толгойн дүрс бүхий 50х50 см хэмжээтэй бай №6-д буудлага гүйцэтгэнэ.

8.6.6. Баг, тамирчид биатлоны төрөлд 2 /хүн нэг бүрт/, патрулийн төрөлд 2 /автомат, гар буу/ байг ашиглана.

8.6.7. Автоматын буудлагын байны аравч нь байнаас багагүй хэмжээтэй, газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийгдсэн 2 хөлтэй байна.

8.6.8. Байны хөлийг байны ард, аравчны баруун, зүүн эрмэгт бэхлүүлнэ.

8.6.9. Байг суурь /газраас/-наас дээш 30 смээс ихгүй өндөрт байрлуулна.

8.6.10. Гар бууны буудлагын байны аравч нь байнаас багагүй хэмжээтэй, газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийгдсэн 1-2 хөлтэй, хөлийг байны ард, аравчны голд /аравч 2 хөл бол баруун, зүүн эрмэгт/ бэхэлсэн байна.

8.6.11. Гар бууны байг газраас 120 см-ээс дээш өндөрт байрлуулна.

8.6.12. Тэмцээнд оролцож байгаа тамирчин буудлагын байны зүүн дээд өнцөгт сугалааны дугаарыг тод харагдахаар тэмдэглэсэн байна.

8.6.13. Онооны шүүгч буудлагын байны баруун дээд өнцөгт тамирчны амжилтыг тодорхой тэмдэглэнэ.

#### **8.7. Хувцаслалт:**

8.7.1. Биатлоны төрөлд оролцох тамирчид нь зориулалтын спорт хувцастай, өвлийн цэрэг малгай, бээлий, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар цээж болон нуруунд байрлуулна.

8.7.2. Патрулийн төрөлд оролцох баг, тамирчид жигд хувцас, бээлийтэй, өвлийн цэрэг малгай, бүстэй, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар цээж болон нуруунд байрлуулна.

8.7.3. Буунд нэмэлтээр оосор, бусад хэрэгсэл хийхийг зөвшөөрнө.

8.7.4. Тэмцээнд оролцох баг, тамирчид хайрагдах, хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх бүх шатны арга хэмжээг авсан байна.

#### **8.8. Буудлагыг гүйцэтгэх, дүгнэх:**

8.8.1. Өвлийн 2 төрөлтийн буудлагын талбайн бүх үйл ажиллагаа нь талбайн ахлах шүүгчийн хяналтан доор зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээний зааврыг чанд мөрдөж явагдана.

8.8.2. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь тамирчдыг тэмцээнд оролцох болон тэмцээний бэлтгэл буудлага хийх тутамд зэвсэг, галт хэрэглэлтэй

харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг нэг бүрчлэн танилцуулж, мөрдүүлэн гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.

8.8.3. Патрулийн төрөлд багийн 4 гишүүн буудлагын талбайн заагт бүрэн ирсний дараа буудлагын талбайд орж, буудлага хийхийг зөвшөөрнө.

8.8.4. Гар бууны буудлагыг 25 м-т, автоматын буудлагыг 100 м-т гүйцэтгэнэ.

8.8.5. Буудлагыг гар дээрээс гүйцэтгэнэ. Оосор ашиглахыг зөвшөөрнө.

8.8.6. Магазинаар тулах, таяг ашиглахыг зөвшөөрөхгүй.

8.8.7. Буудлага гүйцэтгэж байх үед бай унасан тохиолдолд буудлагыг үргэлжлүүлэх, дахин гүйцэтгэх, байг сэргээж босгохыг хориглоно.

8.8.8. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно.

8.8.9. Сум баарсан тохиолдолд сумыг нөхөж олгон талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр буудлагыг үргэлжлүүлнэ.

8.8.10. Буу гацсан тохиолдолд буудлагыг зогсоож, талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр буг солих буюу хэвийн байдалд оруулаад буудлагыг үргэлжлүүлэн гүйцэтгэж болно.

8.8.11. Буудлагын амжилтыг байнд орсон нийт сумны тоогоор дүгнэнэ.

8.8.12. Сум байны захны зураасыг сэтэлсэн тохиолдолд оноонд тооцно.

8.8.13. Байнд хөндлөн /өөр биетээс ойсон/ орсон, сум туссанаас өөр байдлаар үүссэн нүхийг оноонд тооцохгүй.

### **8.9. Тэмцээний зам, замыг туулах:**

8.9.1. Өвлийн 2 төрөлтийн тэмцээний зам нь өгсүүр, уруу, налуу, тэгш газар оролцсон, 90 градусаас багагүй эргэлтүүдийг багтаасан, нийт уралдах зайны 3/1-тэй тэнцэх хэмжээтэй үргэлжилсэн тойрог хэлбэртэй байна.

8.9.2. Замын байдал нь саадгүй, чулуу, шороо, бусад биет ил гараагүй, цанын улыг зурж, гулсалтыг сааруулахааргүй цасаар бүрэн хучигдсан, цанын сонгомол болон тэших техникээр гулгах боломжтой байна.

8.9.3. Патрулийн төрөлд багийн гишүүд нэгийгээ оосор буюу таяг ашиглан илт чирэх үйлдэл хийхийг хориглоно.

8.9.4. Чирэхээс бусад байдлаар дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрөх бөгөөд барианд орохдоо өөрийн хувийн зэвсэг, хэрэглэлийг биедээ авсан байна.

8.9.5. Тэмцээнд гүйцэж түрүүлэх, зам тавьж өгөх:

8.9.5.1. Тэмцээнд оролцож байгаа тамирчид барианд орохоос бусад үед гүйцэж түрүүлэх, зам тавьж өгөх үйлдлийг дүрмийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

8.9.5.2. Тамирчин гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийн өмнө хөдөлгөөний эрчим, хурд, замын нөхцөл, хүрэлцэхүйц хэмжээний зай байгаа эсэхийг тооцно.

8.9.5.3. Уралдааны замд гүйцэж түрүүлэх тамирчин 10 м-ээс ихгүй зайнаас гүйцэх тамирчинд хандан “ЗАМ” гэсэн дохиог амаар өгнө. Энэ үед гүйцэгдэж байгаа тамирчин замаас гарч, арын тамирчинд саад болохооргүйгээр замыг чөлөөлнө.

8.9.5.4. “ЗАМ” дохиог өгснөөс хойш гүйцэгдэж байгаа тамирчин хурдаа нэмэх, гүйцэж түрүүлэхэд нь ямар нэг байдлаар саад хийхийг хориглоно.

8.9.5.5. Тэмцээний маршрутын 1 замтай хэсэгт араас гүйцэж түрүүлэхээр дохио өгсөн тамирчинд боломжтой нөхцөлөөр зам тавьж өгнө.

8.9.5.6. Тэмцээний маршрутын 2-оос дээш замтай хэсэгт аль чөлөөтэй байгаа замыг ашиглан гүйцэж түрүүлэх үйлдлийг хийнэ. Бүх зам чөлөөгүй байгаа тохиолдолд дүрмийн дагуу замыг чөлөөлүүлэн хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

8.9.6. Дараах тохиолдолд гүйцэж түрүүлэхийг хориглоно:

8.9.6.1. Саадыг тойрон гарах үйлдэл хийж байгаа тохиолдолд;

8.9.6.2. Арын тамирчин өөрийг нь гүйцэж түрүүлэх үйлдэл эхэлсэн үед;

8.9.6.3. Гүйцэгдсэн тамирчны хөдөлгөөнд аюул, саад учруулахгүйгээр буцаж замд орох боломжгүй тохиолдолд;

8.9.6.4. Замын эргэлтүүд дээр болон үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг;

### **8.10. Торгууль өгөх, тэмцээнээс хасах:**

8.10.1.Зөрчилтэй болон өөрийн бууруутай үйлдлээс шалтгаалан гараанаас гараагүй тохиолдолд тухайн баг, тамирчны гарааны цаг зогсохгүй үргэлжлэх бөгөөд баг, тамирчид зөрчлөө арилгасны дараа гараанаас гарна.

8.10.2.Маршрутын замыг ямар нэг байдлаар товчилсон, энэ нь замын шүүгчийн протоколоор нотлогдсон тохиолдолд тухайн баг, тамирчны барианд орсон хугацааг хүчингүй болгож, тэмцээнээс хасна.

8.10.3.Зэвсэг, бусад хэрэглэлийг хаяж, үрэгдүүлэх буюу дутуу барианд орсон тохиолдолд дутуу зэвсэг, хэрэглэлийн тоогоор 1 минутын торгууль оногдуулна.

8.10.4.Баг, тамирчид барианд орохдоо өөрийн хувийн зэвсэг, хэрэглэлийг биедээ авч ороогүй тохиолдол бүрт 1 минутын торгууль өгнө.

8.10.5.Тэмцээний төрөл бүрт буудлагын байднд оноогүй сумны тоогоор тухайн баг, тамирчинд 1 минутын торгуулийг өгнө.

8.10.6.Буудлага хийх үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээг /сумлах, буудах, буу шалгах г.м/ зөрчсөн тохиолдолд эхний удаад сануулга өгч, давтсан тохиолдолд 1 минутын торгууль өгнө.

### **8.11. Биатлоны төрөл:**

8.11.1.Биатлоны төрөлд тамирчид хувийн амжилтаар оролцоно

8.11.2.Тамирчид цана, буутай гараанаас гарч 15 км зайг туулах явцад нийт 15 сумаар буудлага хийж барианд орох дасгалыг боловсруулна.

8.11.3.Тэмцээний маршрутын 5 км тутамд байрлалыг /хэвтээ, суугаа, босоо/ сольж буудлагыг гүйцэтгэх ба, байрлал тус бүрт 5 сумаар буудна.

8.11.4.Буудлагыг хэвтээ, суугаа, босоо гэсэн дарааллаар гүйцэтгэнэ.

8.11.5.Биатлоны төрлийг барианд орсон хугацаанаас гарааны цагийг хасан, торгуулийг нэмж, эцсийн цэвэр цагийн бага хугацаагаар байр эзлүүлнэ.

8.11.6.Биатлоны багийн дүнг багийн хоёр тамирчны эцсийн цэвэр цагийн нийлбэрээр гаргаж, бага хугацаагаар байр эзлүүлнэ.

8.11.7.Багийн дутуу оролцсон тамирчны багийн дүнд орох хугацааг тэмцээнд оролцсон нийт тамирчдын хамгийн сүүлийн байр эзэлсэн хугацаан дээр 1 минутыг нэмж тооцон, багийн дүнд оруулна.

#### **8.12. Патрулийн төрөл:**

8.12.1. Патрулийн төрөлд багийн амжилтаар оролцох бөгөөд нэг баг нь багийн ахлагч 1, багийн гишүүн 3, нийт 4 тамирчны бүрэлдэхүүнтэй байна.

8.12.2. Багийн бүрэлдэхүүн цана, буутай гараанаас гарч 10 км зайг туулах явцад баг нийт 12 сумаар буудлага хийж, барианд орох дасгалыг боловсруулна.

8.12.3. Тэмцээний маршрутын 3,3 км тутамд байрлалыг /хэвтээ, суугаа, босоо/ сольж буудлагыг гүйцэтгэх ба байрлал тус бүрт хүн нэг бүр 1 сумаар буудна. Буудлагыг хэвтээ, суугаа, босоо гэсэн дарааллаар гүйцэтгэнэ.

8.12.4. Барианд орсон хугацааг багийн хамгийн сүүлийн хүнээр тооцно.

8.12.5. Патрулийн төрлийг барианд орсон хугацаанаас гарааны цагийг хасан, торгуулийг нэмж, эцсийн цэвэр цагийн бага хугацаагаар байр эзлүүлнэ.

#### **8.13. Өвлийн хоёр төрөлтийн тэмцээний нэгдсэн дүн гаргах:**

8.13.1. Өвлийн хоёр төрөлтийн багийн нэгдсэн дүнг биатлон, патруль төрлүүдэд багаар эзэлсэн байрын нийлбэр дүнгээр гаргаж, бага оноогоор байр эзлүүлнэ.

8.13.2. Багийн оноо тэнцсэн тохиолдолд патрулийн төрлийн амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Есдүгээр бүлэг.**

### **ЦЭРЭГ, СПОРТЫН ЦОГЦОЛБОР ЗУНЫ ОЛОН ТӨРӨЛТ**

9.1. Цэрэг, спортын цогцолбор /ЦСЦ/ зуны олон төрөлтийн тэмцээн нь 18-30, 31-35, 36-40, 41-ээс дээш гэсэн насны ангилал тус бүр эрэгтэй, эмэгтэй төрлөөр явагдана.

9.2. Тэмцээнд тамирчид 100 метрийн гүйлт, холын зайн гүйлт, гранат шидэлт, буудлага, уртад харайх дасгалуудыг боловсруулна.

9.3. ЦСЦ зуны олон төрөлтийн тэмцээнд доорх зүйлийг хориглоно. Үүнд:

9.3.1. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах аюулгүйн арга хэмжээг зөрчих;

9.3.2. Шатаагч, гэрэлтэгч сум болон зөвшөөрөгдөөгүй сум, галт хэрэгслийг тэмцээнд ашиглах;

9.3.3. Хувцас, хэрэглэлийн зөрчилтэй байх;

9.3.4. Тэмцээнд ашиглах буудлагын зэвсэгт дуран, хараа, хэрэгсэл, зөөлөвч, хацравч, бусад зүйлсийг нэмэлтээр суурилуулах;

#### **9.4. Багийн бүрэлдэхүүн:**

9.4.1. Тэмцээнд оролцох нэг баг нь насны ангилал тус бүрт эрэгтэй 1, эмэгтэй 1, нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

9.4.2. Тэмцээний насны ангилалыг тамирчны төрсөн оноор тооцно.

9.4.3. Тэмцээнд насны ангилалын шаардлага хангасан, тухайн тэмцээнийг зохион байгуулах заавар, удирдамжаар зөвшөөрөгдсөн хүн бүр оролцож болно.

9.4.4. Тамирчин доод насны ангилалд оролцож болох ба насны ангилал өгсөж оролцохыг зөвшөөрөхгүй.

**9.5. Тамирчдын гүйцэтгэх дасгал:**

Насны ангилал		Гүйцэтгэх дасгал				
18-30	Эр	100 м	3000 м	Буудлага	Гранат 40 м	уртын харайлт
	Эм	100 м	3000 м	Буудлага	Гранат 25 м	уртын харайлт
31-35	Эр	100 м	3000 м	Буудлага	Гранат 40 м	уртын харайлт
	Эм	100 м	3000 м	Буудлага	Гранат 22 м	уртын харайлт
36-40	Эр	100 м	2000 м	Буудлага	Гранат 35 м	Байрнаас уртад харайлт
	Эм	100 м	3000 м	Буудлага	Гранат 20 м	Байрнаас уртад харайлт
41-ээс дээш	Эр	100 м	1000 м	Буудлага	Гранат 30 м	Байрнаас уртад харайлт
	Эм	100 м	3000 м	Буудлага	Гранат 18 м	Байрнаас уртад харайлт

**9.6. Хувцаслалт:**

9.6.1. Тэмцээнд оролцох тамирчин нь спорт хувцастай, саравчтай малгайтай, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг цээж, нуруунд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

9.6.2. Гүйлт, харайлтын төрлүүдэд хөнгөн атлетикийн тусгай зориулалтын /хадаастай болон товруутай/ спорт гутал хэрэглэхийг зөвшөөрнө.

9.6.3. Тамирчин нь шүүгчийн зөвшөөрснөөр гарын хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлий, өнгөгүй нүдний шилтэй байж болно.

9.6.4. Шүүгчийн дохио, команд сонсогдох нөхцөлийг хангасан чихэвч хэрэглэхийг зөвшөөрнө.

**9.7. Зэвсэг, хэрэглэл:**

9.7.1. Тэмцээнд 7,62 мм-ийн АК, АКМ загварын автомат буу, 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатын загварыг ашиглана.

9.7.2. Тэмцээний буудлагыг спорт бай №4а-д гүйцэтгэнэ.

9.7.3. Буудлагын бай нь 1-2 хөлтэй, хөлийг газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийж, байны ар талд, аравчны голд /2 хөлтэй бол баруун, зүүн эрмэгт/ бэхэлсэн байна.

9.7.4. Буудлагын байг сууринаас /газраас/ дээш 20-30 см өндөрт байрлуулна.

9.7.5. Тэмцээнд оролцож байгаа тамирчин буудлагын байны зүүн дээд өнцөгт сугалааны дугаарыг тод харагдахаар тэмдэглэсэн байна.

9.7.6. Онооны шүүгч буудлагын байны баруун дээд өнцөгт тамирчны амжилтыг тодорхой тэмдэглэнэ.

**9.8. Буудлага:**

9.8.1. Тамирчин 100 метрт байрлах бай №4а-д 1+5 сумаар, хэвтээ байрлалаас буудах дасгалыг боловсруулна.

9.8.2. Буудлагыг хоёр гар дээрээс гүйцэтгэнэ. Оосор ашиглахыг зөвшөөрнө.

9.8.3. Буудах хугацаа 5 минут хүртэл.

#### 9.8.4. Буудлагын төрлийг дүгнэх:

9.8.4.1. Буудлагын аюулгүй ажиллагааны заавар зөрчсөн тамирчныг тэмцээнээс шууд хасаж, буудлагыг зогсоон үлдсэн сумыг хураана.

9.8.4.2. Буудлага хийх үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээг /шүүгчийн командгүйгээр буудлага хийх, сумлах г.м/ зөрчсөн тохиолдолд буудлагыг зогсоож, тухайн тамирчныг тэмцээнээс хасна.

9.8.4.3. Буудлагын амжилтыг байнд туссан онооны нийлбэрээр дүгнэнэ.

9.8.4.4. Сум онооны зураасыг сэтэлсэн тохиолдолд их оноонд тооцно.

9.8.4.5. Байнд хөндлөн /өөр биетээс ойсон/ орсон, сум туссанаас өөр байдлаар үүссэн нүхийг оноонд тооцохгүй.

9.8.4.6. Байнд илүү сум орсон тохиолдолд тухайн тамирчны авсан хамгийн өндөр онооноос эхлэн илүү орсон сумны тоогоор хасаж тооцно.

9.8.4.7. Буудлага гүйцэтгэж байх үед техникийн шалтгаанаас бусад тохиолдолоор бай унавал буудлагыг зогсоож, үлдсэн сумыг хураана. Буудлагыг цааш үргэлжлүүлэх буюу дахин гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

9.8.4.8. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно.

9.8.4.9. Сум баарсан тохиолдолд талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр дахин сумыг олгож, буудлагыг үргэлжлүүлнэ.

9.8.4.10. Буу гацсан тохиолдолд шүүгчийн зөвшөөрлөөр бууны гацааг гаргаад шүүгчээс зөвшөөрөл авсны дараа буудлагыг үргэлжлүүлж болох ба энэ нь буудах хугацаанд нөлөөлөхгүй.

#### 9.9. **Гранат мэргэн шидэлт:**

9.9.1. Тамирчин сорилын 1 ширхэг, тэмцээний 5 ширхэг 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатыг насны ангилалд тохирох зайд байрлах онооны тойрогт мэргэн шидэх дасгалыг боловсруулна.

9.9.2. Гранат мэргэн шидэлтийн талбай нь 1, 3, 5, 7, 9 метрийн диаметр бүхий таван тойрогтой, тойргийн голоос шулуунаар насны ангилалд тохирсон зайд байрлах 200x100 см-ийн хэмжээтэй гранатыг шидэх зурваснаас бүрдэнэ.

9.9.3. Гранатын талбайн үнэлгээ нь голын тойргоос эхлэн гадагш чиглэсэн дарааллаар 15, 11, 7, 4, 2 гэсэн оноотой байна.

9.9.4. Гранатыг спорт хувцас, хувийн номер, саравчтай малгайтай шиднэ.

9.9.5. Гранат шидэх хугацаа 5 минут хүртэл байна.

9.9.6. “ЭХЭЛ” командаар эхлүүлж, “ДУУСГА” командаар дуусгана.

9.9.7. Гранат мэргэн шидэх төрлийг дүгнэх:

9.9.7.1. “ЭХЭЛ” команд өгсөнөөс хойш цаг зогсохгүй хугацаа дуустал үргэлжлэх бөгөөд ямарч нөхцөлд цагийг сунгахгүй.

9.9.7.2. Гранатыг анхны буусан цэгээр үнэлнэ. Шидсэн гранат онооны шугаман дээр буусан тохиолдолд их оноонд тооцно.

9.9.7.3. Үнэлгээг тэмцээний 5 гранатыг шидэж авсан онооны нийлбэрээр дүгнэнэ.

9.9.7.4. Шидсэн гранат газар бугаагүй байхад шидэх талбайн нүүрний зурвасыг шүргэсэн, гишгэсэн, давж алхсан, тамирчны малгай газарт унасан, гараар тулсан тохиолдолд тухайн гранатаар авсан оноог хүчингүйд тооцно.

9.9.7.5. Шүүгч нь шидсэн гранатыг тооцсоныг цагаан туг /дохио/ өргөж, тооцоогүй шидэлтийг улаан туг /дохио/ өргөж илэрхийлнэ.

9.9.7.6. Тамирчин тэмцээний сахилга зөрчих, шүүгчийн шаардлагыг эс биелүүлэх, шүүгчтэй маргалдах, ёс бус үг хэрэглэсэн тохиолдолд доорх торгуулийг өгнө. Үүнд:

9.9.7.6.1. Эхний удаа анхааруулах шар карт;

9.9.7.6.2. Хоёр дах удаад дахин шар карт өгч тухайн гранатыг шидэж авсан оноог хүчингүйд тооцох;

9.9.7.6.3. Гурав дах удаад зөрчил давтагдсан тохиолдолд улаан картаар торгон тухайн тамирчныг тэмцээнээс хасах;

#### **9.10. Уртын харайлт, байрнаас уртад харайлт:**

9.10.1. Уртын харайлтад гүйлтээс нэг хөлөөр түлхэлт авч үсрэн хол зайд харайх дасгалыг гүйцэтгэнэ.

9.10.2. Байрнаас уртад харайлтад түлхэлт авах тавцан дээрээс хоёр хөлийн түлхэлтээр хол харайх дасгалыг гүйцэтгэнэ.

9.10.3. Харайлтыг 10 см зузаан, 20 см өргөн, 120 см урттай, цагаан өнгөөр будсан түлхэлт авах модон тавцангаас гүйцэтгэнэ.

9.10.4. Түлхэлт авах тавцанг элстэй нүхний хязгаараас 1 м зайтай байрлуулсан байна. Харайлтын талбайн элстэй нүхний өргөн 2,75 м, урт нь 7,5 м /байрнаас уртад харайлт 4 м/, уртын харайлтын урьдчилсэн гүйлтийн замын урт нь 40-45 м, өргөн нь 1,20 см доошгүй байна.

9.10.5. Тэмцээний талбайн шүүгчид нь харайлтыг тооцсоныг цагаан, тооцоогүй бол улаан тугийг өргөж мэдэгдэнэ.

#### **9.10.6. Харайлтыг тооцох:**

9.10.6.1. Оролцогч бүр 3 удаа харайлт гүйцэтгэнэ.

9.10.6.2. Тамирчны амжилтыг 3 оролдлогын хамгийн хол, хүчин төгөлдөр харайсан харайлтын амжилтаар тооцож, таблицанд оруулан дүгнэнэ.

9.10.6.3. Уртын харайлтад урьдчилсан гүйлтээс түлхэлт авах тавцан, элстэй нүхэнд хүрэлгүй сул гүйснийг оролдлогод тооцохгүй. Харайлтыг дахин гүйцэтгэнэ.

9.10.6.4. Харайлтын хэмжилтийг тамирчин замын аль хэсгээс харайлтаа эхэлснээс үл хамааран түлхэлт авах тавцангийн урд өнцөгөөс эхлэн тамирчны элсэн дээр хүрсэн мөрний хамгийн ойрын цэг хүртлэх зайг см-ээр хэмжиж гаргана.

9.10.7. Харайлт бүрийн дараа элсийг тэгшилнэ.

#### **9.10.8. Харайлтыг хүчингүйд тооцох:**

9.10.8.1. Урьдчилсан гүйлтээс харайгаагүй ч түлхэлт авах тавцан, элстэй нүхэнд хүрсэн тохиолдолд харайлтыг хүчингүйд тооцно.

9.10.8.2. Харайлтыг гүйцэтгэхдээ түлхэлт авах тавцангийн зурвасаас хэтэрсэн тохиолдолд харайлтыг хүчингүйд тооцно.

#### **9.11. Ойрын болон дундын зайн гүйлт:**

9.11.1.Тамирчид гараанаас гарч насны ангилалд тохирсон зайд гүйж барианд орох дасгалыг гүйцэтгэнэ.

9.11.2.Гүйлтийн тэмцээн нь тойрог замд зохион байгуулагдана.

9.11.3.Тамирчид спорт хувцас, хувийн дугаартай байна.

9.11.4.Хүн нэг бүрийн үзүүлсэн амжилтыг таблицад шилжүүлэн дүгнэнэ.

#### **9.12. Тэмцээний нэгдсэн дүн гаргах:**

9.12.1.Тэмцээн нь насны ангилал, төрөл тус бүрээр хувийн дүн гаргана.

9.12.2.Хувийн нэгдсэн дүнг гаргахдаа тамирчдын дасгал тус бүрт үзүүлсэн амжилтыг “Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангилал”-д заасан цэрэг, спортын цогцолбор зуны олон төрөлтийн тэмцээний таблицын оноонд шилжүүлэн авсан онооны нийлбэрээр дүгнэж, их оноогоор байр эзлүүлнэ.

9.12.3.Хувийн нэгдсэн оноо тэнцсэн тохиолдолд буудлага, гранат, холын зайн гүйлт гэсэн дарааллаар амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

9.12.4.Цэрэг, спортын цогцолбор зуны олон төрөлтийн тэмцээний багийн нэгдсэн дүнг тухайн багаас тэмцээнд оролцсон нийт тамирчны хувийн нэгдсэн дүнгээр авсан онооны нийлбэр буюу их онооны системээр дүгнэж, байр эзлүүлнэ.

9.12.5.Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Аравдугаар бүлэг.**

### **ЦЭРЭГ, СПОРТЫН ЦОГЦОЛБОР ӨВЛИЙН ОЛОН ТӨРӨЛТ**

10.1.Цэрэг, спортын цогцолбор өвлийн олон төрөлтийн тэмцээн нь 18-30, 31-35, 36-40, 41-ээс дээш гэсэн насны ангилал тус бүр эрэгтэй, эмэгтэй төрлөөр явагдана.

10.2.Тэмцээнд тамирчид биатлон, холын зайн цанын гүйлт, гранат шидэлтийн дасгалуудыг боловсруулна.

10.3.Тэмцээн нь биатлон, гранат шидэлт, зайн уралдаан гэсэн дарааллаар зохион байгуулагдана.

10.4.Тэмцээнд ашиглах уралдааны зам, цана, хэрэглэл нь “Гүйлтийн цанын спортын орчин болон сургалтанд тавих шаардлага” стандартын дагуу байна.

10.5.Уралдах тамирчид цанын спортын сонгомол болон тэших техникийг ашиглана.

10.6.Тэмцээнд оролцох үед доорх зүйлийг хориглоно. Үүнд:

10.6.1.Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээг зөрчих;

10.6.2.Шатаагч, гэрэлтэгч сум болон зөвшөөрөгдөөгүй сум, галт хэрэгслийг тэмцээнд ашиглах;

10.6.3. Малгай, бээлийгүй тэмцээнд оролцох, тэдгээрийг ашиглахгүй байх;  
10.6.4. Тэмцээнд ашиглах буудлагын зэвсэгт дуран, хараа, хэрэгсэл, зөөлөвч, хацравч, бусад зүйлсийг нэмэлтээр суурилуулах;

#### **10.7. Багийн бүрэлдэхүүн:**

10.7.1. Тэмцээнд оролцох нэг баг нь насны ангилал тус бүрт эрэгтэй 1 тамирчин, эмэгтэй 1 тамирчин, нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

10.7.2. Тэмцээний насны ангилалыг тамирчны төрсөн оноор тооцно.

10.7.3. Тэмцээнд насны ангилалын шаардлага хангасан, тухайн тэмцээнийг зохион байгуулах заавар, удирдамжаар зөвшөөрөгдсөн хүн бүр оролцож болно.

10.7.4. Тамирчин доод насны ангилалд оролцож болох ба насны ангилал өгсөж оролцохыг зөвшөөрөхгүй.

#### **10.8. Хувцаслалт:**

10.8.1. Тэмцээнд оролцох тамирчин нь бэлтгэлийн буюу спорт хувцастай, бээлий, малгайтай, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг цээж, нуруунд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

10.8.2. Буунд нэмэлтээр оосор, бусад хэрэгсэл хийхийг зөвшөөрнө.

10.8.3. Тэмцээнд оролцох баг, тамирчид хайрагдах, хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх бүх шатны арга хэмжээг авсан байна.

10.8.4. Шүүгчийн дохио, команд сонсогдох нөхцөлийг хангасан чихэвч, зориулалтын нүдний шилтэй байж болно.

#### **10.9. Зэвсэг, хэрэглэл:**

10.9.1. Тэмцээнд 7,62 мм-ийн АК, АКМ, АКМС загварын автомат буу, 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатын загварыг ашиглана.

10.9.2. Тамирчид шаардлага хангасан, өөрийн цана, таягийг хэрэглэнэ.

10.9.3. Тэмцээнд толгойн дүрс бүхий бай №6-д буудлагыг гүйцэтгэнэ.

10.9.4. Буудлагын бай нь 2 хөлтэй, хөлийг газар суурилуулах боломжтой бат бөх материалаар хийж, байны ар талд, аравчны баруун, зүүн эрмэгт бэхэлнэ.

10.9.5. Буудлагын байг сууринаас /газраас/ дээш 20-30 см өндөрт байрлуулна.

10.9.6. Тэмцээнд оролцож байгаа тамирчин буудлагын байны зүүн дээд өнцөгт сугалааны дугаарыг тод харагдахаар тэмдэглэсэн байна. Онооны шүүгч буудлагын байны баруун дээд өнцөгт тамирчны амжилтыг тодорхой тэмдэглэнэ.

#### **10.10. Тэмцээний зам, замыг туулах:**

10.10.1. Тэмцээний зам нь өгсүүр, уруу, налуу, тэгш газар оролцсон, 90 градусаас багагүй эргэлтүүдийг багтаасан, үргэлжилсэн тойрог хэлбэртэй байна.

10.10.2. Замын байдал нь саадгүй, чулуу, шороо, бусад биет ил гараагүй, цанын улыг зурж, гулсалтыг сааруулахааргүй цасаар бүрэн хучигдсан, цанын сонгомол болон тэших техникээр гулгах боломжтой байна.

10.10.3. Барианд орохдоо өөрийн хувийн зэвсэг, хэрэглэлийг биедээ авсан байна.

10.10.4. Тэмцээнд гүйцэж түрүүлэх, зам тавьж өгөх:

10.10.4.1. Тэмцээнд оролцогч тамирчин нь барианд орохоос бусад тохиолдолд гүйцэж түрүүлэх, зам тавьж өгөх үйлдлийг дүрмийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

10.10.4.2. Тамирчин гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийн өмнө хөдөлгөөний эрчим, хурд, замын нөхцөл, хүрэлцэхүйц хэмжээний зай байгаа эсэхийг тооцно.

10.10.4.3. Уралдааны замд гүйцэж түрүүлэх тамирчин 10 м-ээс ихгүй зайнаас гүйцэх тамирчинд хандан “ЗАМ” гэсэн дохиог амаар өгнө. Энэ үед гүйцэгдэж байгаа тамирчин замаас гарч, арын тамирчинд саад болохооргүйгээр замыг чөлөөлнө.

10.10.4.4. “ЗАМ” дохиог өгсний дараа гүйцэгдэж байгаа тамирчин хурдаа нэмэх, гүйцэж түрүүлэхэд нь ямар нэг байдлаар саад хийхийг хориглоно.

10.10.4.5. Тэмцээний маршрутын 1 замтай хэсэгт араас гүйцэж түрүүлэхээр дохио өгсөн тамирчинд боломжтой нөхцөлөөр зам тавьж өгнө.

10.10.4.6. Тэмцээний маршрутын 2-оос дээш замтай хэсэгт аль чөлөөтэй байгаа замыг ашиглан гүйцэж түрүүлэх үйлдлийг хийнэ. Бүх зам чөлөөгүй байгаа тохиолдолд дүрмийн дагуу замыг чөлөөлүүлэн хөдөлгөөнөө үргэлжлүүлнэ.

10.10.5. Дараах тохиолдолд гүйцэж түрүүлэхийг хориглоно:

10.10.5.1. Саадыг тойрон гарах үйлдэл хийж байгаа тохиолдолд;

10.10.5.2. Арын тамирчин өөрийг нь гүйцэж түрүүлэх үйлдлээ эхэлсэн үед;

10.10.5.3. Гүйцэгдсэн тамирчны хөдөлгөөнд аюул, саад учруулахгүйгээр буцаж замд орох боломжгүй тохиолдолд;

10.10.5.4. Замын эргэлтүүд дээр болон үзэгдэлт хязгаарлагдмал хэсэгт гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг;

10.11. **Торгууль өгөх, тэмцээнээс хасах:**

10.11.1. Зэвсэг, хувцас, хэрэглэл, баримт бичгийн зөрчилтэй байх нь тамирчныг тэмцээний гараанаас гаргахгүй байх, тэмцээнээс хасах үндэслэл болно.

10.11.2. Зөрчилтэй болон өөрийн бууруутай үйлдлээс шалтгаалан гараанаас гараагүй тохиолдолд тухайн тамирчны гарааны цаг зогсохгүй үргэлжлэх бөгөөд зөрчлөө арилгасны дараа гараанаас гарна.

10.11.3. Маршрутын замыг ямар нэг байдлаар товчилсон, энэ нь замын шүүгчийн протоколоор нотлогдсон тохиолдолд тухайн тамирчны барианд орсон хугацааг хүчингүй болгож, тэмцээнээс хасна.

10.11.4. Буудлага хийх үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээг /сумлах, буудах, буу шалгах г.м/ зөрчсөн тохиолдолд эхний удаад сануулга өгч, давтсан тохиолдолд 1 минутын торгууль өгнө.

### 10.12. **Тамирчдын гүйцэтгэх дасгал:**

Ангилал		Гүйцэтгэх дасгал		
18-30	Эр	10 км-ийн цанын гүйлт	Гранат 40 м	Биатлон 10 км
	Эм	5 км-ийн цанын гүйлт	Гранат 25 м	Биатлон 5 км
31-35	Эр	10 км-ийн цанын гүйлт	Гранат 40 м	Биатлон 10 км
	Эм	3 км-ийн цанын гүйлт	Гранат 22 м	Биатлон 5 км
36-40	Эр	5 км-ийн цанын гүйлт	Гранат 35 м	Биатлон 7,5 км
	Эм	2 км-ийн цанын гүйлт	Гранат 20 м	Биатлон 3 км
41-ээс дээш	Эр	3 км-ийн цанын гүйлт	Гранат 30 м	Биатлон 5 км
	Эм	1 км-ийн цанын гүйлт	Гранат 18 м	Биатлон 2 км

### 10.13. **Биатлоны төрөл:**

10.13.1. Тамирчид цана, буутай гараанаас гарч насны ангилалд заагдсан зайг туулах явцад 1 удаа 5 сумаар, 100 метрт байрлах бай №6-д хэвтээ байрлалаас буудах дасгалыг гүйцэтгэнэ.

10.13.2. Буудлагыг хоёр гар дээрээс гүйцэтгэнэ. Оосор ашиглахыг зөвшөөрнө.

10.13.3. Биатлоны төрлийг барианд орсон хугацаанаас гарааны цагийг хасан, торгуулийг нэмж, эцсийн цэвэр цагийн бага хугацаагаар байр эзлүүлнэ.

#### 10.13.4. Буудлагыг гүйцэтгэх, дүгнэх:

10.13.4.1. Тэмцээний буудлагын талбайн бүх үйл ажиллагаа нь талбайн ахлах шүүгчийн хяналтан доор зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээний зааврыг чанд мөрдөж явагдана.

10.13.4.2. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь тамирчдыг тэмцээнд оролцох болон тэмцээний бэлтгэл буудлага хийх тутамд зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг нэг бүрчлэн танилцуулж, мөрдүүлэн гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.

10.13.4.3. Буудлага гүйцэтгэж байх үед бай унасан тохиолдолд буудлагыг үргэлжлүүлэх, дахин гүйцэтгэх, байг сэргээж босгохыг хориглоно.

10.13.4.4. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно.

10.13.4.5. Сум баарсан тохиолдолд сумыг нөхөж олгон талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр буудлагыг үргэлжлүүлнэ.

10.13.4.6. Буу гацсан тохиолдолд буудлагыг зогсоож, талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр буг солих буюу хэвийн байдалд оруулаад буудлагыг үргэлжлүүлэн гүйцэтгэж болно.

10.13.4.7. Сум байны захын зураасыг сэтэлсэн тохиолдолд ононд тооцно.

10.13.4.8. Байнд хөндлөн /өөр биетээс ойсон/ орсон, сум туссанаас өөр байдлаар үүссэн нүхийг ононд тооцохгүй.

10.13.4.9. Буудлагын амжилтыг байнд орсон нийт сумны тоогоор дүгнэнэ.

10.13.4.10. Буудлагын байнд оноогүй сумны тоогоор тухайн тамирчинд 1 минутын торгуулийг өгнө.

#### **10.14. Гранат мэргэн шидэлт:**

10.14.1. Тамирчин сорилын 1 ширхэг, тэмцээний 5 ширхэг 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатыг насны ангилалд тохирох зайд байрлах онооны тойрогт мэргэн шидэх дасгалыг боловсруулна.

10.14.2. Гранат мэргэн шидэлтийн талбай нь 1, 3, 5, 7, 9 метрийн диаметр бүхий таван тойрогтой, тойргийн голоос шулуунаар насны ангилалд тохирох зайд байрлах 200x100 см-ийн хэмжээтэй гранатыг шидэх зурваснаас бүрдэнэ.

10.14.3. Гранатын талбайн үнэлгээ нь голын тойргоос эхлэн гадагш чиглэсэн дарааллаар 15, 11, 7, 4, 2 гэсэн оноотой байна.

10.14.4. Гранатыг спорт хувцас, хувийн номер, малгайтай шиднэ.

10.14.5. Гранат шидэх хугацаа 5 минут хүртэл байна.

10.14.6. “ЭХЭЛ” командаар эхлүүлж, “ДУУСГА” командаар дуусгана.

10.14.7. Гранат мэргэн шидэх төрлийг дүгнэх:

10.14.7.1. “ЭХЭЛ” команд өгсөнөөс хойш цаг зогсохгүй хугацаа дуустал үргэлжлэх бөгөөд ямарч нөхцөлд цагийг сунгахгүй.

10.14.7.2. Гранатыг анхны буусан цэгээр үнэлнэ. Шидсэн гранат онооны шугаман дээр буусан тохиолдолд их оноонд тооцно.

10.14.7.3. Үнэлгээг тэмцээний 5 гранатын онооны нийлбэрээр дүгнэнэ.

10.14.7.4. Шидсэн гранат газар буугаагүй байхад шидэх талбайн нүүрний зурвасыг шүргэсэн, гишгэсэн, давж алхсан, тамирчны малгай газарт унасан, гараар газарт тулсан тохиолдолд тухайн гранатаар авсан оноог хүчингүйд тооцно.

10.14.7.5. Шүүгч нь шидсэн гранатыг тооцсоныг цагаан туг /дохио/ өргөж, тооцоогүй шидэлтийг улаан туг /дохио/ өргөж илэрхийлнэ.

10.14.7.6. Тамирчин тэмцээний сахилга зөрчих, шүүгчийн шаардлагыг эс биелүүлэх, шүүгчтэй маргалдах, гранат шидэх үед ёс бус үг хэрэглэсэн тохиолдолд доорх торгуулийг өгнө. Үүнд:

10.14.7.6.1. Эхний удаа анхааруулах шар карт;

10.14.7.6.2. Хоёр дах удаад дахин шар карт өгч тухайн гранатыг шидэж авсан оноог хүчингүйд тооцох;

10.14.7.6.3. Гурав дах удаад зөрчил давтагдсан тохиолдолд улаан картаар торгон тухайн тамирчныг тэмцээнээс хасах;

#### **10.15. Холын болон дундын зайн цанын гүйлт:**

10.15.1. Тамирчид гараанаас гарч насны ангилалд тохирсон зайд маршрутын дагуу цанатайгаар явж, барианд орох дасгалыг гүйцэтгэнэ.

10.15.2. Тамирчид спорт хувцас, хувийн дугаартай байна.

10.15.3. Хүн бүрийн үзүүлсэн амжилтыг таблицад шилжүүлэн дүгнэнэ.

#### **10.16. Тэмцээний нэгдсэн дүн гаргах:**

10.16.1. Тэмцээн нь насны ангилал, төрөл тус бүрээр хувийн дүн гаргана.

10.16.2. Хувийн нэгдсэн дүнг гаргахдаа тамирчдын дасгал тус бүрт үзүүлсэн амжилтыг “Цэрэгжлийн спортын цол, зэргийн нэгдсэн ангилал”-д заасан цэрэг, спортын цогцолбор өвлийн олон төрөлтийн тэмцээний таблицын оноонд шилжүүлэн авсан онооны нийлбэрээр дүгнэж, их оноогоор байр эзлүүлнэ.

10.16.3. Хувийн нэгдсэн оноо тэнцсэн тохиолдолд биатлон, гранат, зайн гүйлт гэсэн дарааллаар амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

10.16.4. Цэрэг, спортын цогцолбор өвлийн олон төрөлтийн тэмцээний багийн нэгдсэн дүнг тухайн багаас тэмцээнд оролцсон нийт тамирчны хувийн нэгдсэн дүнгээр авсан онооны нийлбэр буюу их онооны системээр дүгнэж, байр эзлүүлнэ.

10.16.5. Багийн оноо тэнцсэн тохиолдолд тэнцсэн багуудын тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Арван нэгдүгээр бүлэг.**

### **СААДЫН ЗУРВАС**

11.1. Саадын зурвасын тэмцээнд гараанаас гарч зохиомол саадуудыг заагдсан дарааллын дагуу туулан туг тойрон буцан гүйж барианд орох дасгалыг гүйцэтгэнэ.

11.2. Тэмцээн нь ганцаарчилсан, буухиа гэсэн төрөлд, офицер, ахлагч, эмэгтэй гэсэн ангиллаар зохион байгуулагдана.

11.3. Тэмцээн зохион байгуулах саадын нэгдсэн зурвас нь Цэргийн биеийн тамирын заавар ЦБТЗ-18-д заагдсаны дагуу төхөөрөмжлөгдсөн байна.

11.4. Саадын зурвасын талбай нь 200 м-ийн зохиомол саад, туг тойрч гүйн барианд орох 200 м-ийн гүйлтийн зай, нийт 400 м зай, хэмжээтэй байна.

11.5. Гараа, барианы цэгийг нэг газарт төхөөрөмжлөнө.

11.6. Саадыг туулах, гар гранат шидэх арга барилыг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан, хамгаалалтын болон аюулгүйн арга хэмжээг авсан нөхцөлд өөрийн боломжтой аргаар гүйцэтгэхийг зөвшөөрнө.

#### **11.7. Багийн бүрэлдэхүүн:**

11.7.1. Тэмцээнд оролцох нэг баг нь эрэгтэй офицер 3, эрэгтэй ахлагч 3, эмэгтэй /офицер, ахлагч/ 1 хүн, нийт 7 тамирчинтай байна.

11.7.2. Тэмцээнд цэргийн жинхэнэ алба хаагч оролцоно.

#### **11.8. Зэвсэг хэрэглэл, хувцаслалт:**

11.8.1. Саадын зурвасын тэмцээнд оролцох тамирчин нь дүрэмт хувцас өмсөх зааварт заасны дагуу хээрийн хувцастай, хувийн дугаартай байна. Хувийн дугаарыг зүүн гарын ханцуйнд зүүсэн байх ба мөрний залгаа оёдолоос доош 10-12 см зайд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

11.8.2. Офицерын ангилалд оролцох тамирчид ПМ загварын гар буу, ташаанд зүүх зориулалттай гар бууны гэр /кабур/, буунд 1, нөөц 1 магазинтай, газ эсэргүүцэгч /МО-4, ПМГ-2/-тэй байна.

11.8.3. Ахлагчийн болон эмэгтэй ангилалд болон буухиа төрөлд оролцох тамирчид автомат /АК, АКМ, АКМС/ буу, подсумкатай, буунд 1, подсумканд 2 магазинтай, газ эсэргүүцэгч /МО-4, ПМГ-2/-тэй байна.

11.8.4. Тамирчид уралдах үедээ бууг нуруунд авсан байна.

11.8.5.Тамирчин нь шүүгчийн зөвшөөрснөөр гар хамгаалах зориулалтаар гарын хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлийтэй байж болно.

11.8.6.Буухиа төрлийн шилжүүлэх савх мод нь 30 см урт, 4 см диаметр хэмжээтэй, 50 гр-аас дээш жинтэй байна.

### **11.9. Ганцаарчилсан төрөлд гүйцэтгэх дасгал:**

#### **11.9.1. Гараанд гарах:**

11.9.1.1.“ГАРААНДАА” командаар саадын нэгдсэн зурвасын гарааны шугамны ард, сугаар хавчин, гарыг биеийн хажууд барьж, газарт доош харан хэвтэнэ. Гарын хурууны үзүүр гарааны шугамны ард байрлана.

11.9.1.2.“АНХААР” командаар гараар түлхэн биеийг газраас хөндийрүүлж, нэг хөлийг татаж, хагас нугалан тулж, гүйхэд бэлтгэнэ.

11.9.1.3.“МАРШ” командаар гараанаас гарна.

#### **11.9.2. Эрэгтэй тамирчид саадыг туулах:**

11.9.2.1.Гарааны шугамнаас гарч 20 м гүйлтийн хэсгийг туулан 1 метр өргөн 1,5 метр гүнтэй шуудуун дээгүүр харайх;

11.9.2.2.8 метр урт дамнуургаар дамжин гүйх;

11.9.2.3.11 метр урт, 40 см өндөр “Торон саад”-ыг алгасалгүй туулах;

11.9.2.4.1 метр зайтай “Унанга мод” саадны намханых нь дээгүүр давж, өндрийн доогуур шурган гарах;

11.9.2.5.2x2,5x3 метр өргөн, 1 метр гүнтэй жалганы 2 метрийн өргөн хэсгээр харайж гарах;

11.9.2.6.“Сүлжээ хороо”-г сүлжиж туулах;

11.9.2.7.2 метрийн өндөртэй “Ханан саад”-ыг давах;

11.9.2.8.“Эвдэрсэн босоо шат”-аар авирч, “Эвдэрсэн гүүр”-ний хөндлөвч дээгүүр гүйн, сэтэрсэн хэсгийг харайн гарч захын үзүүрээс газарт үсрэн буух;

11.9.2.9.“Эвдэрсэн шат” саадны эхний гурван шат тус бүрийг гараар тулж даван, үлдсэн шатны доогуур шургаж гүйх;

11.9.2.10. 2 цонхтой 1.1 метр өндөр “Эвдэрсэн хана” саадыг дээд талын цонхоор шурган гарах;

11.9.2.11. “Харилцах шуудуу бүхий худаг” саадны харилцах шуудуугаар дамжин гарч, шуудуунаас 30 м зайд байрлах кабинд 2 ш Ф-1 сургуулийн гранатыг шидээд нүхнээс үсрэн гарах;

11.9.2.12. 2 метр нүхэн дунд байрлуулсан хайсан дээгүүр гишгэн давах;

11.9.2.13. “Эвдэрсэн байшин”-гийн 1 давхрын цонхноос 2 дугаар давхрын цонхонд авиран гарч дамнуурга модоор дамжин тавцангуудыг ашиглан үсэрч буух;

11.9.2.14. 1 метр гүнтэй шуудуун дээгүүр харайн гарч тэмдэглэсэн туг тойроод, эргэн гүйж барианд орох;

#### **11.9.3. Эмэгтэй тамирчид саадыг туулах:**

11.9.3.1.Гарааны шугамнаас гарч 20 м гүйлтийн хэсгийг туулан 1 метр өргөн 1,5 метр гүнтэй шуудуун дээгүүр харайх;

11.9.3.2.8 метр урт дамнуургаар дамжин гүйх;

11.9.3.3.11 метр урт, 40 см өндөр “Торон саад”-ыг алгасалгүй туулах;

11.9.3.4.1 метр зайтай “Унанга мод” саадны намханых нь дээгүүр давж, өндрийн доогуур шурган гарах;

11.9.3.5.2x2,5x3 метр өргөн, 1 метр гүнтэй жалганд орж үсрэн гарах;

- 11.9.3.6. “Сүлжээ хороо”-г сүлжиж туулах;
- 11.9.3.7. “Эвдэрсэн босоо шат”-аар авирч, “Эвдэрсэн гүүр”-ний хөндлөвч дээгүүр гүйн, сэтэрсэн хэсэг дээгүүр харайн гарч шатаар доош буух;
- 11.9.3.8. “Эвдэрсэн шат” саадны эхний хоёр шат тус бүрийг гараар тулж даван, үлдсэн шатны доогуур шургаж гүйх;
- 11.9.3.9.2 цонхтой 1.1 метр өндөр “Эвдэрсэн хана” саадыг дээд талын цонхоор шурган гарах;
- 11.9.3.10. “Харилцах шуудуу бүхий худаг” саадны харилцах шуудуугаар дамжин гарч, шуудуунаас 20 м зайд байрлах кабинд 2 ш Ф-1 сургуулийн гранатыг шидээд, нүхнээс үсрэн гарах;
- 11.9.3.11. Нүхэн дунд байрлуулсан хайсан дээгүүр гишгэн давах;
- 11.9.3.12. Нэг метр гүнтэй шуудуун дээгүүр харайн гарч тэмдэглэсэн тугийг тойроод, эргэн гүйж барианд орох;

#### **11.10. Буухиа төрөл:**

- 11.10.1. Буухиа төрөлд багийн 4 гишүүн оролцоно.
- 11.10.2. Буухиа төрөлд багийн гишүүн тус бүр саадын зурвасын замын нэг хэсэгт уралдан, савх модыг нөгөө тамирчинд шилжүүлж өгөх дасгалыг гүйцэтгэнэ.
- 11.10.3. Тамирчид савх модыг шилжүүлэх зурвасаас хэтрүүлэлгүй дамжуулна.
- 11.10.4. Эхний тамирчин гараанаас гарснаар багийн цагийг эхлүүлж, сүүлийн хүн барианд орсноор цагийг тооцно.
- 11.10.5. Гараанд гарах: “ГАРААНДАА” командаар багийн гишүүд өөрийн туулах хэсгийн гараанд очиж бэлтгэх бөгөөд эхний тамирчин савх модыг барин эхлэх гарааны шугамны ард босоо гараанаас гүйхэд бэлтгэнэ. Багийн бүх гишүүд тус тусын гараанд бэлэн болсны дараа “МАРШ” командаар эхний тамирчин гүйлтийг эхлэнэ.
- 11.10.6. Буухиа төрөлд тамирчид саадыг туулах:
  - 11.10.6.1. Нэг дэх тамирчин:
    - 11.10.6.1.1. Гарааны шугамнаас гарч 20 м гүйлтийн хэсгийг туулан 1 метр өргөн 1,5 метр гүнтэй шуудуун дээгүүр харайх;
    - 11.10.6.1.2. Найман метр урт дамнуургаар дамжин гүйх;
    - 11.10.6.1.3. “Торон саад”-ыг алгасалгүй туулах;
    - 11.10.6.1.4. “Унанга мод” саадны намханых нь дээгүүр давж, өндрийн доогуур шурган гарах;
    - 11.10.6.1.5. 1 метр гүнтэй жалганы 2 метрийн өргөн хэсгээр харайж гараад дараагийн тамирчинд савх модыг шилжүүлэх;
  - 11.10.6.2. Хоёр дах тамирчин:
    - 11.10.6.2.1. “Сүлжээ хороо”-г сүлжиж туулах;
    - 11.10.6.2.2. Хоёр метрийн өндөртэй “Ханан саад”-ыг давах;
    - 11.10.6.2.3. “Эвдэрсэн босоо шат”-аар авирч, “Эвдэрсэн гүүр”-ний хөндлөвч дээгүүр гүйн, сэтэрсэн хэсгийг харайн гарч хөндлөвчний үзүүрээс газарт үсрэн буух;
    - 11.10.6.2.4. “Эвдэрсэн шат” саадны эхний гурван шат тус бүрийг гараар тулж даван, үлдсэн шатны доогуур шургаж гүйх;
    - 11.10.6.2.5. Хоёр цонхтой 1.1 метр өндөр “Эвдэрсэн хана” саадыг дээд

талын цонхоор шурган гараад дараагийн тамирчинд савх модыг шилжүүлэх;

11.10.6.3. **Гурав дах тамирчин:**

11.10.6.3.1. “Харилцах шуудуу бүхий худаг” саадны харилцах шуудуугаар дамжин гарч, шуудуунаас 30 м зайд байрлах кабинд 2 ш Ф-1 сургуулийн гранатыг шидээд нүхнээс үсрэн гарах;

11.10.6.3.2. Нүхэн дунд байрлуулсан хайсан дээгүүр гишгэн давах;

11.10.6.3.3. “Эвдэрсэн байшин”-гийн 1 давхрын цонхноос 2 дугаар давхрын цонхонд авиран гарч дамнуурга модоор дамжин тавцангуудыг ашиглан үсэрч буух;

11.10.6.3.4. Нэг метр гүнтэй шуудуун дээгүүр харайн гарч туг тойроод эргэн гүйж дараагийн тамирчинд савх модыг шилжүүлэх;

11.10.6.4. **Дөрөв дэх тамирчин:**

11.10.6.4.1. Гурав дах тамирчнаас савх модыг авч, 180 м замыг гүйж туулан барианд орох;

11.11. **Алдааг тооцох:**

11.11.1. Саадуудын нэгж, хэсгүүдийг орхигдуулах, алгасах;

11.11.2. Шуудуунууд дээгүүр харайх үед хөндлөн буюу ташиж харайх;

11.11.3. Дамнуурга модыг үзүүр хэсэгт хүрэлгүй дундаас нь үсэрч гарах;

11.11.4. Торон саадыг алгасах, торонд хүрэх;

11.11.5. “Унанга мод” саадыг алгасах, давах үед хөлийг газарт хүргээгүй;

11.11.6. Жалгыг хөндлөн буюу 2 м-ээс бага хэсгээр харайх;

11.11.7. “Сүлжээ хороо”-ны хөндлүүдийг шургаж туулах;

11.11.8. “Ханан саад”-ыг туулахдаа тулгуур баганаас түлхэлт авах;

11.11.9. “Эвдэрсэн шат”-ыг хөл газарт хүргэлгүй дараагийн шатыг туулах;

11.11.10. Нүхэн дундах хайсан дээгүүр гишгэлгүй гарах;

11.11.11. “Эвдэрхий байшин”-гийн дамнуурга мод, тавцанг алгасан буух;

11.11.12. Саадын зурвасын талбайн туг, тэмдэглэгээг тойролгүй өнгөрөх;

11.12. **Торгууль өгөх, тэмцээнээс хасах:**

11.12.1. Зөрчилтэй болон өөрийн бууруутай үйлдлээс шалтгаалан гараанаас гараагүй тохиолдолд тухайн тамирчны гарааны цаг зогсохгүй үргэлжлэх бөгөөд зөрчлөө арилгасны дараа гараанаас гарна.

11.12.2. Тамирчин саадын зурвасын тухайн саадыг заавал туулж байж дараагийн саадын зүг хөдөлгөөнийг үргэжлүүлнэ.

11.12.3. Тамирчин саадын зурвасыг ямар нэг шалтгаанаар бүрэн туулаагүй тохиолдолд гүйсэн хугацааг хүчингүй болгож, дүрмийн 10.16.5 дах заалтын дагуу дүгнэнэ.

11.12.4. Тэмцээнд дараах тохиолдолд торгуулийн хугацааг тооцож, гүйлтийн цаг дээр нэмж дүгнэнэ. Үүнд:

11.12.4.1. Дасгалыг буруу гүйцэтгэсэн тохиолдол бүрт 20 сек торгууль;

11.12.4.2. Алдаа тус бүрт 10 сек торгууль;

11.12.4.3. Кабинд ороогүй гранат тус бүрт 10 сек торгууль;

11.12.4.4. Зэвсэг, хувцас, хэрэглэл дутуу барианд орвол 10 сек торгууль;

11.12.4.5. Савх модыг шилжүүлэхдээ зурвасаас давбал 10 сек торгууль;

#### 11.13. **Саадын зурвасыг шүүх:**

11.13.1. Саадын зурвасын талбайн шүүгч нь тамирчныг дагаж явах ба цагаан, улаан туг ашиглан алдаа, торгуулийг нарийн бичигт харагдахуйцаар дээш өргөн, мэдэгдэнэ.

11.13.2. Нарийн бичиг шүүгч талбайн шүүгчийн заалтыг нэг бүрчлэн тэмдэглэн, торгуулийг тооцож, эцсийн цэвэр цагийг гаргана.

11.13.3. *Цагаан туг:* Тамирчны гаргасан алдаа бүрт 1 удаа өргөж заана.

11.13.4. *Улаан туг:* Кабинд ороогүй гранатын тоогоор болон дасгалыг буруу гүйцэтгэх, саадыг туулаагүй тохиолдол бүрт 1 удаа өргөж заана.

#### 11.14. **Саадын зурвасын тэмцээний нэгдсэн дүн гаргах:**

11.14.1. Тэмцээний ганцаарчилсан төрөл тус бүрээр хувийн дүн гаргана.

11.14.2. Хувийн нэгдсэн дүнг тамирчдын саадын зурвас туулсан хугацаан дээр торгуулийн хугацааг нэмж гарган, бага оноогоор байр эзлүүлнэ.

11.14.3. Буухиа тэмцээний дүнг багийн саадын зурвас туулсан хугацаан дээр багийн нийт гишүүдийн авсан торгуулийг нэмж гарган, бага оноогоор байр эзлүүлнэ.

11.14.4. Саадын зурвасын тэмцээний багийн нэгдсэн дүнг гаргахдаа тухайн багийн бүх гишүүдийн ганцаарчилсан төрөлд саадын зурвас туулсан хугацааны нийлбэр дээр буухиа тэмцээний багийн амжилтын хугацааг нэмж, бага оноогоор дүгнэж, байр эзлүүлнэ.

11.14.5. Багийн дутуу оролцсон тамирчны багийн дүнд орох хугацааг тэмцээнд оролцсон нийт тамирчдын хамгийн сүүлийн байр эзэлсэн хугацаан дээр 1 минутыг нэмж тооцон, багийн дүнд оруулна.

## **Арван хоёрдугаар бүлэг.**

### **МЭРГЭН БУУДАГЧИЙН ХОЁР ТӨРӨЛТ**

12.1. Мэргэн буудагчийн хоёр төрөлтийн тэмцээн нь биатлон /ганцаарчилсан/, патруль /багийн/ гэсэн төрлүүдээр явагдана.

12.2. Тэмцээний талбай нь саадын зурвас, гар бууны буудлагын талбай, мэргэн буудагчийн буудлагын талбай, гранатын талбай, хиймэл саадууд гэсэн зохион байгуулалттай төхөөрөмжлөгдөх ба нийт замын урт 1 км байна.

12.3. Тэмцээнд доорх зүйлийг хориглоно. Үүнд:

12.3.1. Зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах аюулгүйн арга хэмжээг зөрчих;

12.3.2. Шатаагч, гэрэлтэгч сум, галт хэрэгсэлийг тэмцээнд ашиглах;

12.3.3. Хувцас, зэвсэг, хэрэглэлийн зөрчилтэй байх;

#### 12.4. **Багийн бүрэлдэхүүн:**

12.4.1. Тэмцээнд оролцох нэг баг нь биатлоны төрөлд 2 тамирчин, патрулийн төрөлд 4 тамирчин, нийт 6 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна.

12.4.2. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцоно.

12.4.3. Тэмцээний биатлоны төрөлд оролцсон тамирчин патрулийн төрөлд оролцохыг зөвшөөрнө.

## **12.5. Зэвсэг, хэрэглэл:**

12.5.1. Биатлоны тамирчид СВД загварын мэргэн буудагчийн винтов, өдрийн ПСО-1 М2 хараа, ПМ загварын гар буу, ташаанд зүүх зориулалттай бууны гэр /кабур/, гар буунд 1, нөөц 1 магазинтай байна.

12.5.2. Патрулийн багийн гишүүд доорх зэвсэг, хэрэгсэлтэй байна. Үүнд:

12.5.2.1. Хослолын мэргэн буудагчийн винтовоор буудах тамирчин өдрийн ПСО-1 М2 хараа, хэрэгсэлтэй СВД загварын мэргэн буудагчийн винтов болон ПМ гар буутай, ташаанд зүүх зориулалттай бууны гэр /кабур/, буунд 1, нөөц 1 магазинтай,

12.5.2.2. Хослолын гар бууны буудлага хийх тамирчин автомат /АК, АКМ, АКМС/ буу, подсумкатай, буунд 1, подсумканд 2 магазинтай байна.

12.5.3. Мэргэн буудагчийн хоёр төрөлтийн тэмцээнд дуу чимээний РГД-5 гар гранатын загвар, буудлагын төрөлд поппер байг ашиглана.

## **12.6. Хувцаслалт:**

12.6.1. Тэмцээнд оролцох тамирчин нь дүрэмт хувцас өмсөх зааварт заасны дагуу хээрийн хувцастай, хувийн дугаартай байна.

12.6.2. Хувийн дугаарыг зүүн гарын ханцуйнд зүүсэн байх ба мөрний залгаа оёдолоос доош 10-12 см зайд шүүгч, үзэгчдэд харагдахуйцаар байрлуулна.

12.6.3. Буунд нэмэлтээр оосор, бусад хэрэгсэл хийхийг хориглоно.

12.6.4. Тамирчин нь шүүгчийн зөвшөөрснөөр гар хамгаалах зориулалтаар гарын хурууны нэгдүгээр үе ил гарсан бээлийтэй байж болно.

## **12.7. Дасгалыг гүйцэтгэх дараалал, дүгнэх арга:**

12.7.1. Тамирчид гараанаас гарч саадын зурвасыг гүйцэтгэх дарааллын дагуу туулан цааш гүйж гар бууны буудлагын талбай, мэргэн буудагчийн буудлагын талбайг дамжин тус бүрийн буудлагыг хийгээд, гранатын талбайд ирж дасгалыг гүйцэтгээд цааш гүйж хиймэл саадуудыг туулан барианд орно.

12.7.2. Патрулийн төрлийн буудлага, гранат, хиймэл саадын талбайнуудын заагт тухайн хослол бүрэн ирсний дараа шүүгчийн командаар талбайд орж, дасгалыг гүйцэтгэхийг зөвшөөрнө.

12.7.3. Саадуудыг туулах үед бууг өөрийн ашигтай байрлалд авч болно.

### **12.7.4. Саадын зурвас туулах:**

12.7.4.1. Саадын нэгдсэн зурвасыг /ЦБТЗ-2018-ын хавсралт №6/ хэсэгчилсэн байдлаар баруунаас зүүн тийш туулна. Үүнд:

12.7.4.1.1. Гараанаас гарч хоёр цонх бүхий 1.1 м-ийн өндөртэй “Эвдэрхий ханан саад”-ын дээд цонхоор шурган гарах;

12.7.4.1.2. Хоёр метрийн өндөртэй “Ханан саад”-ыг давах;

12.7.4.1.3.1 метр гүнтэй “Жалга”-нд орж үсрэн гарах;

12.7.4.1.4. 11 метр урт “Торон саад”-ыг мөлхөлтөөр туулж, буудлагын талбай чиглэн, хөдөлгөөнөө үргэлжлүүлэх;

### **12.7.5. Буудлагын талбай дахь ажиллагаа:**

12.7.5.1. Тамирчин хэсэг тус бүрийн галын заагт ирж задгай сумыг авч магазиныг сумлаж, бууг цэнэглээд талбайн шүүгчийн командаар целийг устгана.

12.7.5.2. Буудлагын талбайд дараах дасгалыг боловсруулна. Үүнд:

12.7.5.2.1. *ПМ гар бууны буудлага*: холын зай 15 м, 3 ширхэг цээжин дүрс бай №6, сумны тоо 3 ш, буудах байдал босоо байрлалаас, гар дээрээс;

12.7.5.2.2. *СВД бууны буудлага*: холын зай 300 м, 3 ширхэг цээжин дүрс бай №6, сумны тоо 3 ш, буудах байдал хэвтээ байрлалаас, тулгуур дээрээс;

12.7.5.3. Буудлагыг дуусгасны дараа бууг шалгаж, гал хамгаалагчийг хаагаад талбайн шүүгчид илтгээд дараагийн талбай руу хөдөлгөөн үйлдэнэ.

**12.7.6. Гар гранат шидэх:**

12.7.6.1.25 метрын зайд, 1,5 метр диаметрийн хэмжээтэй тойрогт байрлах босоо дүрсэн бай №8-д 2 ширхэг дуу чимээний РГД-5 гар гранатыг шиднэ.

12.7.6.2. Босоо дүрсийг оносон эсвэл тойргийн хүрэн дотор гранат унасан тохиолдолд целийг устгасанд тооцно.

**12.7.7. Хиймэл саад түүлах:**

12.7.7.1. Тэмээн шатыг шат алгасалгүй 2 гар ашиглан дамжиж туулна.

12.7.7.2. 10 метр урт бартаат хэсгийг алгасалгүй, гүйлтээр туулна.

12.7.7.3. 16 кг жинтэй 1 ш галт хэрэглэлтэй хайрцгийг 20 м газарт зөөж тэмдэгт заагт хүргээд цааш гүйж барианд орно.

**12.8. Буудлагыг гүйцэтгэх:**

12.8.1. Тэмцээний буудлагын талбайн бүх үйл ажиллагаа нь талбайн ахлах шүүгчийн хяналтан доор зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүйн арга хэмжээний зааврыг чанд мөрдөж явагдана.

12.8.2. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь тамирчдыг тэмцээнд оролцох болон тэмцээний бэлтгэл буудлага хийх тутамд зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг нэг бүрчлэн танилцуулж, мөрдүүлэн гарын үсэг зуруулсан байх шаардлагатай.

12.8.3. Тамирчид буудлагын дасгалыг гүйцэтгэхдээ винтовын тулгуур хэрэглэх, гар бууг барих нөхцөлийг өөрийн сонголтоор ашиглаж болно.

12.8.4. Ерөнхий шүүгч тэмцээний явцад аюулгүй ажиллагааны шаардлага зөрчигдөхөөс сэргийлэн буудлагын секторт хүн, мал, нисэх хэрэгсэл илэрсэн, гал түймэр, осол аюул гарсан, байны төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд дасгал гүйцэтгэж байгаа тамирчны гүйцэтгэж байгаа дасгалыг зогсоож, цагийг барина.

12.8.5. Сум баарсан, буу гацсан тохиолдолд нэг гарыг өргөж буудлагын шүүгчид мэдэгдэхээс өөр үйлдэл хийхийг хориглоно. Энэ тохиолдолд цаг зогсохгүй.

12.8.6. Сум баарсан тохиолдолд сумыг нөхөж олгон талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр буудлагыг үргэлжлүүлж болно.

12.8.7. Буу гацсан тохиолдолд буудлагыг зогсоож, талбайн ахлах шүүгчийн зөвшөөрлөөр бууг солих буюу хэвийн байдалд оруулаад буудлагыг үргэлжлүүлэн гүйцэтгэж болно.

**12.9. Торгууль өгөх, тэмцээнээс хасах:**

12.9.1. Зөрчилтэй болон өөрийн бууруутай үйлдлээс шалтгаалан гараанаас гараагүй тохиолдолд тухайн тамирчны гарааны цаг зогсохгүй үргэлжлэх бөгөөд зөрчлөө арилгасны дараа шүүгчийн зөвшөөрлөөр гараанаас гарч болно.

12.9.2.Тамирчин саадын зурвас болон хиймэл саадын тухайн саадыг заавал туулж байж дараагийн саадын зүг хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ. Багийн гишүүнээс дэмжлэг авч болох ба туулж чадаагүй тохиолдолд баг, тамирчдыг шууд хасна.

12.9.3.Тэмцээнд оролцож байгаа тамирчид буудлагын дасгал гүйцэтгэх явцад буудлагын аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчвөл тэмцээнээс хасна.

12.9.4.Патрулийн төрөлд багийн гишүүн эмнэлгийн болон бусад шалтгаанаар замаас гарах, дүрмийн зөрчил гарган тэмцээнээс хасагдаж хүн дутуу болсон тохиолдолд цааш хөдөлгөөнийг үргэлжлүүлэхийг хориглох бөгөөд тухайн багийн гүйсэн цагийг хүчингүйд тооцно.

12.9.5.Саадын зурвас, хиймэл саадын дасгалыг буруу гүйцэтгэсэн тохиолдол бүрт 10 сек торгууль өгнө.

12.9.6.Буудлага, гранат шидэх дасгалыг боловсруулах үед оноогүй целийн тоогоор торгуулийн тойрог гүйцэтгэнэ.

12.9.7.Торгуулийн нэг тойргийн хэмжээ 100 м байна.

12.9.8.ПМ-ын буудлагад оноогүй целийн тоогоор торгуулийн 1 тойрог гүйцэтгэнэ.

12.9.9.СВД-ын буудлагад оноогүй целийн тоогоор торгуулийн 2 тойрог гүйцэтгэнэ.

12.9.10. Гранатын талбайд босоо дүрсийг оноогүй буюу тойргийн хүрээнд ороогүй гранат бүрт торгуулийн 1 тойрог гүйцэтгэнэ.

12.9.11. Патрулийн төрөлд буудлага, гранатын талбайн оноогүй целийн торгуулийг мэргэн буудагчийн хослолоороо гүйцэтгэнэ.

12.9.12. Зэвсэг, хувцас, хэрэглэл дутуу барианд орсон тохиолдол тус бүрт нь 30 сек торгууль оногдуулна.

#### **12.10. Биатлоны төрөл:**

12.10.1. Биатлоны төрөлд тамирчид хувийн амжилтаар оролцоно

12.10.2. Тамирчид гараанаас гарч дүрмэнд заасан дасгалыг гүйцэтгэх дараалал, дүгнэх аргачлалын дагуу замыг туулж, барианд орно.

12.10.3. Биатлоны төрлийг тамирчдын барианд орсон хугацаанаас гарааны цагийг хасан, торгуулийг нэмж, эцсийн цэвэр цагийн бага хугацаагаар байр эзлүүлнэ.

12.10.4. Биатлоны багийн дүнг багийн хоёр тамирчны эцсийн цэвэр цагийн нийлбэрээр гаргаж, бага хугацаагаар байр эзлүүлнэ.

12.10.5. Багийн дутуу оролцсон буюу тэмцээнээс хасагдсан тамирчны багийн дүнд орох хугацааг тэмцээнд оролцсон нийт тамирчдын хамгийн сүүлийн байр эзэлсэн хугацаан дээр 1 минутыг нэмж тооцон, багийн дүнд ороулна.

#### **12.11. Патруль төрөл:**

12.11.1. Патрулийн төрөлд багийн 4 тамирчин хуваагдан 2 хүнтэй мэргэн буудагчийн 2 хослол болж буухиа хэлбэрээр оролцоно.

12.11.2. Хослол тус бүрийн 1-р хүн ПМ буугаар, 2-р хүн СВД буугаар буудлага гүйцэтгэнэ. Гранат шидэх, сумтай хайрцаг зөөх дасгалыг бүгд биелүүлнэ.

12.11.3. Шүүгчийн дохиогоор багийн эхний хослол гараанаас гарч дасгалуудыг зааврын дагуу гүйцэтгээд барианд ирмэгц мэргэн буудагчийн хослолын 1-р хүн 1-р хүнд, 2-р хүн 2-р хүний гарт хүрч бууриаг дамжуулна. Буухиаг аваад 2 дугаар хослол зааврын дагуу дасгалыг адил нөхцөлөөр туулан барианд орно.

12.11.4. Хугацааг багийн эхний хослол гараанаас гарснаар эхлүүлж, хоёр дах хослолын сүүлийн хүн барианд орсноор зогсоож, багийн гүйсэн хугацааг тооцно.

12.11.5. Патрулийн багийн эцсийн цэвэр цагийг гаргахдаа багийн гүйсэн хугацаан дээр саадын зурваст багийн авсан нийт торгуулийн хугацааг нэмж тооцно.

12.11.6. Патрулийн тэмцээний нэгдсэн дүнг гаргахдаа оролцсон багуудыг эцсийн цэвэр цагийн амжилтаар нь жагсааж, бага хугацаагаар байр эзлүүлнэ.

12.11.7. Гүйцэтгэх дасгал:

12.11.7.1. Мэргэн буудагчийн 1-р хослол гараанаас гарч саадын зурвасыг дүрмийн дагуу туулан буудлагын талбайд ирнэ.

12.11.7.2. Хослолын 1-р хүн гар буугаар буудах дасгалыг боловсруулна. Хослолын 2-р хүн тэмдэглэсэн заагт хүлээж байна. Цааш гүйж мэргэн буудагчийн талбайд очно.

12.11.7.3. Хослолын 2-р хүн СВД буудах дасгалыг боловсруулна. Хослолын 1-р хүн тэмдэглэсэн заагт хүлээж байна.

12.11.7.4. Цааш хөдөлгөөнийг үргэлжлүүлэн гранатын талбайд очиж хүн тус бүр 1 ширхэг РГД-5 гар гранатыг шиднэ.

12.11.7.5. Хиймэл саадуудыг зааврын дагуу туулж, хүн бүр 1 хайрцаг галт хэрэглэл зөөж байрлуулаад гүйж барианд орон буухиаг дамжуулна.

**12.12. Тэмцээний нэгдсэн дүн гаргах:**

12.12.1. Тэмцээний багийн нэгдсэн дүнг биатлон, патруль төрлүүдэд багаар эзэлсэн байрын нийлбэр дүнгээр гаргаж, бага оноогоор байр эзлүүлнэ.

12.12.2. Багийн оноо тэнцсэн тохиолдолд патрулийн төрлийн амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.

## **Арван гуравдугаар бүлэг.**

### **МАРШ, ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН,**

13.1. Марш тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн нь тэмцээнийг явуулах тухай батлагдсан тушаал, Цэрэгжлийн спортын дүрмийн хүрээнд боловсруулагдсан тусгай заавар, удирдамжийн дагуу зохион байгуулагдана.

13.2. Тэмцээний явуулах журам нь тухайн тэмцээнийг зохион байгуулах байгууллагаас батлагдаж, гарсан заавар, удирдамжаар тодорхойлогдоно.

13.3. Марш тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнийг зохион байгуулах үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг чанд мөрдөж, гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх бүх шатны арга хэмжээг авсан байна.

13.4. Тэмцээнийг цаг агаарын нөхцөл, баг, тамирчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан орчин, стандартын шаардлага хангасан талбай, техник, хэрэглэл, хэрэгслэл, тоног төхөөрөмжийг ашиглан явуулна.

13.5. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцоно.

13.6. Тэмцээнд оролцох бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр оролцох ба эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

### **13.7. Тэмцээний төрөл, оролцох бүрэлдэхүүн.**

13.7.1. Марш тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн нь доорх төрлөөр зохион байгуулагдана. Үүнд:

13.7.1.1. Байнгын бүрэлдэхүүний салаа – 26+2 ЦАХ;

13.7.1.2. Хугацаат цэргийн алба хаагчдын салаа – 26+2 ЦАХ;

13.7.1.3. Эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг – 8+2 ЦАХ;

13.7.2. Тэмцээнд оролцох нэг салаа, тасгийн бүрэлдэхүүнд салаа, тасгийн захирагч, эмнэлэгийн зааварлагч, буудагч, нөөц 2 тамирчин багтана.

13.7.3. Салааны захирагчаар оролцох тамирчин офицер цолтой байна.

### **13.8. Хувцаслалт, зэвсэг, хэрэглэл.**

13.8.1. Тэмцээнд оролцогч нь дүрэм хувцас өмсөх зааврын дагуу зуны хээрийн хувцастай, офицерууд ПМ загварын гар буу, ташаанд зүүх зориулалттай бууны гэр /кабур/, офицер цүнхтэй, бусад бүрэлдэхүүн автомат /АК, АКМ, АКМС/ буу, подсумкатай, нөөц 2 магазинтай байна.

13.8.2. Эмнэлэгийн зааварлагч нь анхны тусламж үзүүлэх боломжтой эм, боох материал, хэрэгсэл бүхий эмнэлэгийн зааварлагчийн цүнхтэй байна.

13.9. Тэмцээнд оролцох бүх бүрэлдэхүүн МО-4 загварын холбох хоолой бүхий шүүгч газ эсэргүүцэгчтэй байна.

13.10. Тэмцээнд 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатын загвар, буудлагын бай №4а, №5а, №6, хамгаалалтын буудлагын бай болон поппер байг ашиглана.

### **13.11. Марш тусгай бэлтгэлийн тэмцээнд гүйцэтгэх ажиллагаа.**

13.11.1. Тэмцээний зам нь тэгш, өгсүүр, уруу, налуу, 1-2 өндөрлөг оролцсон газар оронд төхөөрөмжлөгдөнө. Замын маршрутын урт эр 10 км, эм 6 км байна.

13.11.2. Марш тусгай бэлтгэлийн тэмцээн нь гарааны өмнө гүйцэтгэх ажиллагаа, маршийн үед гүйцэтгэх ажиллагаа гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

13.11.3. Гарааны өмнө гүйцэтгэх ажиллагаанд жагсаал, гардан тулааны үзүүлэх тоглолт, норматив /биеийн тамир, галын бэлтгэл, ҮОХЗХБ/-ын бэлтгэл орно.

13.11.4. Маршийн үед гүйцэтгэх ажиллагаанд гранат /мэргэнд буюу холд шидэлт/, саадын зурвас, буудлага /гар буу, автомат, СВД, хамгаалалтын буудлага/, эзлэгдсэн объектыг чөлөөлөх, тактикийн ажиллагаа, байгалийн саад /дүүжин шат, савалгаат гүүр, тороосон дамнуурга/ туулах, усан саад, хөнөөлийн голомтод ажиллах, цэргийн байр зүйн цэгүүдийг олох, хордсон газар орныг туулж, химийн нормативийг биелүүлэх дасгалууд багтсан байна.

### **13.12. *Марш тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээний дүн гаргах.***

13.12.1. Маршийн замыг туулж байрианд орсон гүйлтийн цэвэр цагаараа эхний 5 байр эзэлсэн салаа /тасаг/-уудад 5, 4, 3, 2, 1 минутын шагналыг байр эзэлсэн дарааллаар олгож, нэгдсэн дүнд оруулан тооцно.

13.12.2. Марш тактикийн аварга салаа, тасаг шалгаруулах тэмцээний нэгдсэн дүнг салаа, тасгуудын маршид гүйсэн ерөнхий цагаас гарааны өмнөх болон маршийн үед гүйцэтгэсэн ажиллагааны явц дах шагналын хугацааг хасах, торгуулийн хугацааг нэмэх журмаар цэвэр цагийн хамгийн бага цагаар гаргаж, байр эзлүүлнэ.

## **Арван дөрөвдүгээр бүлэг.**

### **ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**

14.1. Цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн нь тэмцээнийг зохион байгуулах тухай батлагдсан тушаал, Цэрэгжлийн спортын дүрмийн хүрээнд боловсруулагдсан тусгай заавар, удирдамжийн дагуу явагдана.

14.2. Тэмцээний явуулах журам нь тухайн тэмцээнийг зохион байгуулах байгууллагаас батлагдаж, гарсан заавар, удирдамжаар тодорхойлогдоно.

14.3. Тэмцээнд зөвхөн цэргийн жинхэнэ алба хаагч оролцоно.

14.4. Цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах үед зэвсэг, галт хэрэглэлтэй харьцах үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг чанд мөрдөж, гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх бүх шатны арга хэмжээг авч ажиллана.

14.5. Тэмцээнийг цаг агаарын нөхцөл, тамирчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан орчин, стандартын шаардлага хангасан талбай, техник, хэрэглэл, хэрэгслэл, тоног төхөөрөмжийг ашиглан явуулна.

### **14.6. *Тэмцээний төрөл, оролцох бүрэлдэхүүн.***

14.6.1. Цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээний багийн бүрэлдэхүүнд батальоны захирагч, ротын захирагч, салааны захирагч, эмэгтэй офицер, эрэгтэй ахлагч, эмэгтэй ахлагч гэсэн ангилалд тус бүр 1 цэргийн алба хаагч, нийт 6 тамирчин оролцоно.

14.6.2. Тэмцээний төрлүүдэд заагдсан тухайн албан тушаалд ажиллаж байгаа болон адилтгах албан тушаалд ажиллаж байгаа цэргийн жинхэнэ алба хаагч оролцож болно.

14.6.3. Батальон захирагч, ротын захирагч, салааны захирагч, эмэгтэй офицерын ангилалд оролцох тамирчин нь офицер цолтой байна.

14.6.4. Ахлагчийн төрөлд ахлагчийн албанд эрэгтэй 3 түүнээс дээш жил, эмэгтэй 1 түүнээс дээш жил ажиллаж байгаа цэргийн алба хаагч оролцоно.

#### **14.7. Тэмцээнд гүйцэтгэх ажиллагаа.**

14.7.1.Тэмцээний зам нь тэгш, өгсүүр, уруу, налуу, 1-2 өндөрлөг оролцсон газар оронд төхөөрөмжлөгдөнө. Замын маршрутын урт эр 10 км, эм 6 км байна.

14.7.2.Тэмцээн нь онолын болон дадлагын /марш/ гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

14.7.3.Онолын хэсэгт тактик, тусгай тактик, гадаад хэлний бэлтгэл, компьютер, оюуны чадавхийн түвшин, биеийн тамирын бэлтгэлжилт гэсэн үзүүлэлтүүд орно.

14.7.4.Дадлагын хэсэгт тогтоосон зайд марш үйлдэх ажиллагаа орно.

14.7.5.Маршид гүйх явцад тамирчин гранат /мэргэнд буюу холд/ шидэлт, саадын зурвас, буудлага /гар буу, автомат, СВД/, эзлэгдсэн объектыг чөлөөлөх, техникийн бэлтгэл, тактикийн ажиллагаа, байгалийн саад /дүүжин шат, савалгаат гүүр, тороосон дамнуурга/ туулах, усан саад, хөнөөлийн голомтод ажиллах, цэргийн байр зүйн цэгүүдийг олох, хордсон газар орныг туулж, химийн нормативийг биелүүлэх дасгалуудыг гүйцэтгэнэ.

#### **14.8. Хувцаслалт, зэвсэг, хэрэглэл.**

14.8.1.Тэмцээнд оролцогчид нь бүгд дүрэм хувцас өмсөх зааврын дагуу зуны хээрийн хувцастай, GPS болон луужин, автомат бууны жад, жижиг хүртэй, МО-4 загварын холбох хоолой бүхий шүүгч газ эсэргүүцэгчтэй байна.

14.8.2.Офицерууд гар буу /ПМ/, ташаанд зүүх зориулалттай гар бууны гэр /кабур/, офицер цүнх, дарцагтай, ахлагч нар автомат /АК, АКМ, АКМС/ буу, подсумкатай, буунд 1, подсумканд 2 магазинтай байна.

14.8.3.Тэмцээнд 600 грамм жинтэй Ф-1 хориглолтын гранатын загвар, буудлагын бай №4а, №5а, №6 болон поппер байг ашиглана.

#### **14.9. Тэмцээний дүн гаргах.**

14.9.1.Маршийн замыг туулж барианд орсон гүйлтийн цэвэр цагаараа эхний 5 байр эзэлсэн тамирчдад байр эзэлсэн дарааллаар 5, 4, 3, 2, 1 минутын шагналыг олгож, нэгдсэн дүнд оруулна.

14.9.2.Төрөл тус бүрт хувийн дүнг гаргана. Тамирчдын хувийн дүнг маршид гүйсэн ерөнхий цагаас онолын хэсгийн болон маршид гүйх явцад авсан шагналын хугацааг хасах, торгуулийн хугацааг нэмэх журмаар цэвэр цагийг гаргаж, хамгийн бага цагаар гаргаж, байр эзлүүлнэ.

14.9.3.Тэмцээний багийн нэгдсэн дүнг багийн нийт гишүүдийн эзэлсэн байруудын нийлбэрээр гаргаж, бага оноогоор байр эзлүүлнэ.

14.9.4.Багийн оноо тэнцсэн тохиолдолд тамирчдын амжилтын илүүг харгалзан дүгнэж, байр эзлүүлнэ.